

ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БОЛОН СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Журмын агуулга

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	2
ХОЁР. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА	
1. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих нийтлэг шаардлага	4
2. Систем ажиллуулах хүсэлт гаргагч.....	6
3. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч болон систем ажиллуулах хүсэлт гаргагчийн мэдээллийн аюулгүй байдалд тавих шаардлага.....	7
ГУРАВ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ НЭМЭЛТ ШААРДЛАГА	
4. Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх.....	8
5. Төлбөрийн карт гаргах.....	9
6. Төлбөрийн карт хүлээн авах.....	9
7. Цахим мөнгө гаргах.....	10
8. Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх.....	11
9. Аутсорсингийн үйлчилгээ авах.....	11
10. Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх.....	12
ДӨРӨВ. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ	12
ТАВ. ХҮСЭЛТ СУДЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ	12
ЗУРГАА. ЗӨВШӨӨРӨЛ ТАТГАЛЗАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ	13
ДОЛОО. ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД ТАВИХ ШААРДЛАГА	
10.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн нийтлэг эрх, үүрэг.....	15
11. Төлбөрийн карт гаргагчийн эрх, үүрэг.....	17
12. Төлбөрийн карт хүлээн авагчийн эрх, үүрэг.....	17
13. Төлбөрийн карт гаргагч, хүлээн авагчийн нийтлэг эрх, үүрэг.....	18
14. Цахим мөнгө гаргагчийн эрх үүрэг	19
15. Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг.....	20
НАЙМ. СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ	20
ЕС.ИННОВАЦИЙН ОФФИС	21
ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, ТАЙЛАН МЭДЭЭ	
16. Хяналт.....	22
17. Тайлан мэдээ	24
18. Хариуцлага.....	25
ХАВСРАЛТ	26-57

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Монголбанкнаас Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлагыг тодорхойлох, хүсэлт гаргагч нь хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг хангасан эсэхийг судалж хянах, зөвшөөрөл олгох, татгалзах, зөвшөөрлийн нөхцөл, зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагыг тогтоох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.3 Энэ журамд заасан нэр томъёог Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тодорхойлсон утгаар ойлгоно.
- 1.4 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1 болон 10.2-т заасны дагуу Монголбанк нь энэ журмын шаардлагыг хангасан этгээдэд дараах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дангаар нь эсхүл хамтад нь олгоно. Үүнд:
 - 1.4.1 Төлбөрийн карт гаргах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;
 - 1.4.2 Төлбөрийн карт хүлээн авах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;
 - 1.4.3 Цахим мөнгө гаргах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;
 - 1.4.4 Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;
 - 1.4.5 Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх;
 - 1.4.6 Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;
 - 1.4.7 Аутсорсингийн үйлчилгээ авах;
 - 1.4.8 Систем ажиллуулах.
- 1.5 Төлбөрийн карт гаргах, хүлээн авах, цахим мөнгө гаргах зөвшөөрөл бүхий этгээд болон банкинд энэ журмын 1.4.4-т заасан зөвшөөрлийг олгосонд тооцно.
- 1.6 Төлбөр тооцооны төлөөлөгч нь зөвхөн банк байна.
- 1.7 Энэ журмын 1.4.1-1.4.3-т заасан зөвшөөрөл эзэмшигч, банкнаас бусад этгээд мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэх бол энэ журмын 1.4.4-т заасан зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлнэ.
- 1.8 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.3-т заасан системийг зөвхөн Монголбанк ажиллуулна.

- 1.9 Монголбанкны Банксүлжээ системийн оператор, Үндэсний цахим гүйлгээний төв нь энэ журамд заасан систем ажиллуулах этгээдэд тавигдах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллахаас гадна хэрэгжилтэнд нь Монголбанкны төлбөрийн системийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэгжээс хяналт тавина.
- 1.10 Монгол Улсын Сангийн Яам, Монголын үнэт цаасны клирингийн төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, банк, банкны эрх хүлээн авагчаас бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-д заасны дагуу Банксүлжээ системд шууд бусаар оролцох буюу төлбөр тооцооны төлөөлөгчийн Монголбанкн дахь дансаар дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэнэ.
- 1.11 Оролцогч хоорондын бага дүнтэй гүйлгээ болон картын гүйлгээг Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв эсвэл Монголбанкны зөвшөөрөл бүхий клирингийн системээр дамжуулах бөгөөд төлбөр тооцоог Монголбанк дээрх шууд оролцогчийн дансаар гүйцэтгэнэ.
- 1.12 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн дотоод гүйлгээнд буюу тухайн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч дээрх данс хооронд хийж буй гүйлгээнд энэ журмын 1.11 дэх заалт хамаарахгүй.
- 1.13 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь QR код ашиглан гүйлгээ дамжуулах, хүлээн авах бол Монголбанкнаас баталсан QR кодын стандарт, шаардлагыг мөрдөж ажиллана.
- 1.14 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.3-т заасан системийг “Банксүлжээ систем” гэж ойлгоно.
- 1.15 ISO/IEC 7810 ID-1 стандартын бэлдэц дээр картын мэдээллийг хэвлэсэн, EMV стандарт хангасан чип эсхүл соронзон тууз бүхий төлбөрийн хэрэгслийг биет төлбөрийн карт гэнэ.
- 1.16 Цахим худалдаанд ашиглагдах, биетээр хэвлэгдээгүй картын мэдээлэл бүхий төлбөрийн хэрэгслийг биет бус төлбөрийн карт гэнэ.
- 1.17 Карт, картын мэдээлэл ашиглан, эсхүл хэрэглэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хооронд тохирсон аливаа хэлбэрийн мэдээлэл ашиглан гүйлгээ үүсгэж буй төхөөрөмж, програм хангамжийг цахим мэдээ үүсгэгч гэнэ.
- 1.18 Карт хүлээн авагчийн системд холбогдсон, карт, картын мэдээллээр идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг АТМ гэнэ;
- 1.19 Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг цахим мөнгө, карт гэх мэт бэлэн бус төлбөрийн хэрэгсэл ашиглан банкин дахь эсхүл цахим мөнгө гаргагч дээрх дансанд хүлээн авах хувь хүн, хуулийн этгээдийг мерчант гэнэ.
- 1.20 Карт хүлээн авагчийн системд холбогдсон, төлбөр хийх зориулалтаар мерчант дээр байршуулсан, карт, картын мэдээллээр идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг ПОС төхөөрөмж гэнэ.
- 1.21 Карт хүлээн авагч өөрийн салбар, нэгжид байршуулж, системдээ холбосон, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг ПОБ гэнэ.
- 1.22 Олон улсад зөвшөөрөгдсөн картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран гаргасан, тухайн байгууллагын карт хүлээн авах сүлжээнд ашиглах боломжтой ₮ картыг “Ко-брэнд ₮” карт гэнэ.

- 1.23 Карт гаргагчийг бусдаас ялгах зорилгоор олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагаас болон Монголбанкнаас олгосон картын дугаарын эхний 6-8 оронг илэрхийлэх тоон дарааллыг БИН дугаар гэнэ.
- 1.24 Картын чипийг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ үүсгэхийг чип уншуулах гэнэ.
- 1.25 Картын зайнаас мэдрэгч чипийг цахим мэдээ үүсгэгчид зайнаас уншуулан картын гүйлгээ үүсгэхийг зайнаас унших гэнэ.
- 1.26 Карт ашиглаж, цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар мөнгөн хөрөнгө шилжүүлэх, дансны үлдэгдэл шалгах, орлого, зарлага хийх, ПИН код өөрчлөх, баримт авах зэрэг үйлдлийг картын гүйлгээ гэнэ.
- 1.27 Хэрэглэгчийн дансны дугаар, картын мэдээллийг агуулсан өгөгдлийг системд дамжуулахаас өмнө токен буюу тусгай кодоор орлуулах, токеныг дансны дугаарыг илэрхийлсэн өгөгдлөөр эргүүлэн сольж өгөх үйлчилгээг “Токенжуулах” гэнэ.

ХОЁР. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих нийтлэг шаардлага

- 2.1 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:
- 2.1.1 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-т заасан шууд бус оролцогч байх тохиолдолд төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий нэг банкныг өөрийн төлбөр тооцооны төлөөлөгчөөр сонгосон байх;
- 2.1.2 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь клирингийн эсхүл төлбөр тооцооны системийн оролцогч болохоос өмнө тухайн системийн оператортай техникийн туршилт хийж баталгаажуулсан байх;
- 2.1.3 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу хэрэглэгчийг таньж мэдэх үйл ажиллагааны дотоод журам, заавар боловсруулсан байх;
- 2.1.4 Гадны болон дотоод хүчин зүйлээс шалтгаалж үйл ажиллагаа тасалдах, осол, гэмтэл гарах үед үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан төлөвлөгөөг баталсан байх;
- 2.1.5 Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг найдвартай хадгалах, хамгаалах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахуйц мэдээллийн технологийн дэд бүтэцтэй байх;
- 2.1.6 Хэрэглэгчийн гүйлгээ амжилттай хийгдсэн эсэх талаарх мэдээллийг аливаа үйлчилгээний шимтгэл, хураамжгүйгээр тухай бүр хэрэглэгчид мэдэгдэх боломжийг нээсэн байх.
- 2.1.7 Хэрэглэгчийн хийсэн аливаа гүйлгээний түүх, гүйлгээний үе шат бүрийн талаарх мэдээллийг гаргах боломж бүхий системтэй байх.

- 2.1.8 Төлбөрийн үйлчилгээтэй холбоотойгоор хэрэглэгч болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гаргасан гомдол, санал, маргаантай гүйлгээг цаг тухайд нь хүлээн авч шийдэх, тэдгээрт лавлагаа мэдээлэл өгөх дотоод журам, заавар боловсруулсан байх;
- 2.1.9 Компани татан буугдах, зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлснээс үүдэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зогсоох үед хэрэглэгчийн хохирлыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээний талаар тусгасан журам, заавартай байх;
- 2.1.10 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгасан байх шаардлагатай:
- 2.1.10.1 Гэрээнд оролцогч талуудын албан ёсны нэр, хаяг;
 - 2.1.10.2 Талуудын эрх, үүрэг;
 - 2.1.10.3 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг нууцлах үүргийн тухай болон хэрэглэгчийн мэдээллийг хэрхэн хадгалах, ашиглах тухай;
 - 2.1.10.4 Хэрэглэгч нь ПИН код буюу гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн хэрэглэгч мэдэж байх тоо, үсэг, тэмдэгтийн дараалал, түүнтэй адилтгах бусад мэдээллийг нууцлах, түүнийг хаяж үрэгдүүлсэн, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;
 - 2.1.10.5 Хэрэглэгч нь өөрийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;
 - 2.1.10.6 Гүйлгээ хийх үед хэрэглэгчийг таньж баталгаажуулах арга, хэрэгсэл болон хэрэглэгчийг таньж баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;
 - 2.1.10.7 Хэрэглэгч тухайн гүйлгээг илгээхийг зөвшөөрсөн, баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;
 - 2.1.10.8 Гүйлгээг буцаан дуудах, цуцлах нөхцөл, хугацаа;
 - 2.1.10.9 Хэрэглэгч гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;
 - 2.1.10.10 Компани татан буугдах, зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлснээс үүдэн өөрийн үйл ажиллагааг зогсоох үед хэрэглэгчийн хохирлыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.
 - 2.1.10.11 Бусад.
- 2.1.11 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь мерчанттай байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгасан байх шаардлагатай:
- 2.1.11.1 Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийг бэлэн мөнгөний нэгэн адил төлбөрт хүлээн авах тухай;
 - 2.1.11.2 Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний төлбөр, татвар, торгууль, хураамжийн төлбөр (цаашид “төрийн үйлчилгээний төлбөр” гэх), орон сууцны ус, цахилгаан, дулааныг ханган нийлүүлэх байгууллага, СӨХ, конторын төлбөр (цаашид “орон сууцны хэрэглээний төлбөр” гэх)-ийг карт ашиглан төлөх

гүйлгээнээс бусад картын гүйлгээ хийх тохиолдолд карт эзэмшигчээс картаар үйлчилсний шимтгэл авахгүй байх тухай;

2.1.11.3 ПОС төхөөрөмжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн гэрээнд заасан байршилд буюу урьдчилан тодорхойлсон нутаг дэвсгэрийн хүрээнд байршуулах;

2.1.11.4 ПОС төхөөрөмжийн эзэмшигч болон ашиглах байршил өөрчлөгдөх тухай бүр гэрээг шинэчлэн байгуулах;

2.1.11.5 Мерчантаас гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;

2.1.11.6 Компани татан буугдах, зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлснээс үүдэн өөрийн үйл ажиллагааг зогсоох үед мерчантын хохирлыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.

2.1.12 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн нийт хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй байх;

2.1.13 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн нийт хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

2.1.14 Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бүрдүүлсэн байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь гуравдагч этгээдийн шаардлагаас ангид, тухайн этгээдийн санхүүгийн тайлан, татвар төлөлтийн тайлангаар батлагдсан хууль ёсны үйл ажиллагааны орлого байх.

Систем ажиллуулах хүсэлт гаргагчид тавих шаардлага

2.2 Систем ажиллуулах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

2.2.1 Санхүүгийн мэдээний олон улсын ISO20022, ISO8583 ISO27001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх;

2.2.2 Монголбанкны Банксүлжээ системийн үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй туршилт хийж, Монголбанкнаас дүгнэлт авсан байх;

2.2.3 Системийн ажиллах цагаар оролцогчийн санал, хүсэлтийг хүлээн авах, мэдээлэл солилцох байнгын ажиллагаатай лавлах утас, цахим суваг нээсэн байх;

2.2.4 Систем ажиллуулах хүсэлт гаргагч нь төлбөр тооцооны эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монголбанкны шаардлагын дагуу оролцогчийн үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тухайн оролцогчийн төлбөр тооцооны данс дахь мөнгөн хөрөнгийн боломжит дүнгээс илүүгүй байхаар хязгаарлах техник технологийн боломжийг бүрдүүлсэн байх;

2.2.5 Системийн дүрэмтэй байх бөгөөд дүрэмд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлсийг тусгаж, Монголбанкинд хянуулсан байна:

- 2.2.5.1 Оролцогчид тавигдах шаардлага, мэдээллийн технологи болон бусад техникийн шаардлага;
 - 2.2.5.2 Оролцогчийг системд бүртгэх, бүртгэлээс хасах үйл ажиллагаа;
 - 2.2.5.3 Гүйлгээ дамжуулах, баталгаажуулах, үр дүнгийн тооцоолол хийх, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг Монголбанканд дамжуулах хуваарь, зарчим; буцаан дуудах, гүйлгээг эцсийн, үл буцаагдах гэж үзэх нөхцөл;
 - 2.2.5.4 Оролцогч төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүй болсны улмаас системд учруулах эрсдэлийг хязгаарлах, удирдах арга хэмжээ;
 - 2.2.5.5 Тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах тухай (системд өөрчлөлт, шинэчлэлт хийх, төлөвлөгөөт зогсолт болон гэнэтийн саатал гарсан үед авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тусгасан байх);
 - 2.2.5.6 Маргаан шийдвэрлэх зарчим, хугацаа;
 - 2.2.5.7 Шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг тооцох, суутгах зарчим.
- 2.2.6 Систем ажиллуулах хүсэлт гаргагч нь системийн дүрмийг боловсруулахдаа оролцогчид ба бусад операторын эрх тэгш байдлыг хангах, ижил нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх зарчмыг баримталсан байх;
 - 2.2.7 Систем ажиллуулах этгээдийн нийт хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй байх;
 - 2.2.8 Систем ажиллуулах этгээдийн нийт хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх.

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх болон систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн мэдээллийн аюулгүй байдалд тавигдах нийтлэг шаардлага

- 2.3 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч болон систем ажиллуулах хүсэлт гаргагч нь мэдээллийн аюулгүй байдалтай холбоотойгоор дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.3.1 Нууцлал аюулгүй байдлын систем болон програм хангамж ашигласан байх;
 - 2.3.2 Өөрийн дотоод сүлжээ, вэбсайт, сервер болон бусад техник холболт руу гаднаас халдах боломжгүй байх нөхцлийг хангаж, байгууллагын мэдээллийн системийг аливаа сэжиг бүхий эсхүл зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалах галт хана суурилуулсан байх бөгөөд энэ нь интернэт болон бусад сүлжээгээр дамжин байгууллагын мэдээллийн системд хандах бүх хандалтыг авч үзсэн байх;
 - 2.3.3 Хэрэглэгчийн мэдээлэлд нэвтэрч буй бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгосон байх;

- 2.3.4 Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;
- 2.3.5 Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер, серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;
- 2.3.6 Мэдээллийн технологийн үндсэн систем, түүний техник төхөөрөмж (цаашид үндсэн төв гэх) гэмтэх, аливаа саатал гарах үед үйл ажиллагааг шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх хүчин чадал бүхий нөөц систем, мэдээллийн сан, дэд бүтэцтэй байх (цаашид нөөц төв гэх);
- 2.3.7 Нөөц төвийг үндсэн систем байршиж буй газар нутгаас хамгийн багадаа 30 км зайд байршуулсан байх;
- 2.3.8 Үндсэн төв болон нөөц төвийг үндсэн болон нөөц шугамаар холбосон байх
- 2.3.9 Оролцогчийн үндсэн ба нөөц төвийг операторын үндсэн төвтэй холбосон байх
- 2.3.10 Оролцогчийн үндсэн төвийг операторын нөөц төвтэй холбосон байх
- 2.3.11 Үндсэн болон нөөц систем байршиж буй барилга байгууламжид агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, аваар осол мэдрэгч төхөөрөмж байршуулсан байхаас гадна тухайн объектуудыг цахилгааны нэмэлт эх үүсвэртэй холбосон байх;
- 2.3.12 Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулсан байх.

ГУРАВ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргах

- 3.1 Төлбөр тооцооны төлөөлөгч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 36.5 дахь хэсэгт заасны дагуу дараах шаардлагыг хангасан байна.
- 3.1.1 Банкны үйл ажиллагааны энгийн зөвшөөрөлтэй байх;
- 3.1.2 Сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд Банксүлжээ систем дэх бусад клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог цаг тухайд нь найдвартай гүйцэтгэж, заавал байлгах нөөцөө бүрэн хангасан байх;
- 3.1.3 Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор Монголбанк дахь өөрийн харилцах дансны мөнгөн хөрөнгөөс тодорхой дүнг нөөцлөх буюу тусгаарлахыг зөвшөөрсөн байх;

Карт гаргах хүсэлт гаргагч

3.2 Карт гаргах хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-т заасан шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 3.2.1 Чиптэй карт нь олон улсын EMV стандартын шаардлагыг хангасан байх;
- 3.2.2 Карт нь тухайн картыг хүлээн авах зөвшөөрөл бүхий бүх оролцогчийн ПОС төхөөрөмж дээр уншигдаж худалдан авалт, буцаалтын болон төлбөрийн гүйлгээ хийх боломжтой байх;
- 3.2.3 Карт нь тухайн картыг хүлээн авах зөвшөөрөл бүхий бүх оролцогчийн АТМ, ПОБ төхөөрөмж дээр уншигдаж бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ, дансны үлдэгдэл шалгах гүйлгээ хийх боломжтой байх;
- 3.2.4 Цахим худалдаа хийх буюу карт ашиглан интернэтээр бараа, ажил үйлчилгээний төлбөр төлөх, худалдан авалт хийх боломжтой байх;
- 3.2.5 Карт гаргагч нь хэрэглэгчийн зан төлөв, хэрэглээнд суурилсан сэжигтэй гүйлгээг илрүүлэх чадамж бүхий програм хангамжтай байх;
- 3.2.6 Ухаалаг гар утас болон бусад цахим төхөөрөмжид картын мэдээллийг суулгаж гүйлгээ үүсгэх тохиолдолд тухайн мэдээллийг олон улсын стандартын дагуу токенжуулдаг байх;
- 3.2.7 Дотоодод болон олон улсад төлбөрт ашиглагдах Үндэсний карт буюу “Ү” лого бүхий “Ү карт” гаргах бол картын загвар нь энэ журмын хавсралт 11-15-д заасан стандарт, шаардлагыг хангасан байх.

Карт хүлээн авах хүсэлт гаргагч

3.3 Карт хүлээн авах хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-т заасан шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

- 3.3.1 ПОС төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд олон улсын “EMV (contact level 1, level 2 type approval) стандарт”-ын сертификат бүхий ПОС төхөөрөмжтэй байх;
- 3.3.2 ПОС төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн гаргасан картыг өөрийн ПОС төхөөрөмж дээр хүлээн авч, худалдан авалт болон буцаалтын гүйлгээ хийх боломжтой байх;
- 3.3.3 АТМ, ПОБ төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн гаргасан картыг өөрийн АТМ, ПОБ төхөөрөмж дээр хүлээн авч, бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ, дансны үлдэгдэл шалгах гүйлгээ хийх боломжтой байх;
- 3.3.4 Цахим худалдааны гүйлгээг хүлээн авах тохиолдолд бүх оролцогчийн картыг хүлээн авч, цахим худалдааны гүйлгээ хийх боломжтой байх;
- 3.3.5 АТМ болон бусад цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж дээрх карт хэрэглэгчийн болон картын мэдээллийг хуулбарлан авах зорилгоор суурилуулсан гадны биетийг илрүүлэх чадамж бүхий системийг суурилуулсан байх;

- 3.3.6 АТМ болон хэрэглэгч өөртөө үйлчилж, гүйлгээ үүсгэх боломж бүхий цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж байршиж буй газарт хэрэглэгчийн нүүр царайг таних, түүний эргэн тойрныг хамарсан бичлэг хийх хяналтын камер суурилуулсан байх;
- 3.3.7 Картын систем нь ухаалаг гар утас болон бусад цахим төхөөрөмжид суурилсан, олон улсын стандартын дагуу токеноор орлуулсан картын мэдээлэл бүхий гүйлгээг хүлээн авч, дамжуулах боломжтой байх.

Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагч

- 3.4 Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-т заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:
- 3.4.1 Банкнаас бусад цахим мөнгө гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөгөөс доошгүй байх;
- 3.4.2 Цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөөр баталгаажиж, мөнгөн дүн нь цахим хэлбэрээр хадгалагддаг байх;
- 3.4.3 Цахим мөнгө гаргагчаас бусад мерчант төлбөрт хүлээн зөвшөөрсөн байх;
- 3.4.4 Цахим мөнгөний үйлчилгээ эсвэл цахим хэтэвч нь бусдаас ялгарах өөрийн гэсэн оноосон нэртэй байх;
- 3.4.5 Цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөдөг байх;
- 3.4.6 Цахим мөнгө гаргах, түүнийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлэх, гүйлгээ хийх болон төлбөр төлөх үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байх;
- 3.4.7 Харилцагчийн болон дансны бүрэн мэдээллийг агуулсан, нарийвчилж хөтлөх боломж бүхий бүртгэлийн системтэй байх бөгөөд тус систем нь:
- 3.4.7.1 Цахим мөнгөний хөдөлгөөнийг хянах;
- 3.4.7.2 Цахим мөнгөний тоо хэмжээг тогтоох;
- 3.4.7.3 Оролцогчийн зөвшөөрсөн хэмжээнээс илүү гүйлгээ хийх, данс андуурсан зэрэг санамсаргүй үйлдэл, луйврын болон сэжигтэй гүйлгээг илрүүлэх, гүйлгээг зогсоох, буцаах, түүнээс үүсэх маргааныг шийдвэрлэх боломжтой байна.
- 3.4.8 Цахим мөнгө гаргагч нь банк бол баталгааны дансыг Монголбанканд, банкнаас бусад хуулийн этгээд бол дараах шаардлагыг хангасан банкинд байршуулна:
- 3.4.8.1 Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 12 (арван хоёр) сарын турш тогтмол хангаж ажилласан системийн нөлөө бүхий банк эсхүл;
- 3.4.8.2 Монголбанкнаас тухайн банкинд хамгийн сүүлд хийсэн газар дээрх иж бүрэн шалгалтаар “Сайн” үнэлгээ авсан системийн нөлөө бүхий банк.

3.4.9 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн гаргасан цахим мөнгөнд баталгаа болгож гаргасан, түүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг 100 (зуун) хувь байршуулах дансыг баталгааны данс гэнэ.

3.4.10 Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн ситемийн тухай хуулийн 35.4 дэх хэсэгт заасан нөхцөлийг хангасан байна.

3.4.11 Бүртгэлгүй хэрэглэгч нь цахим мөнгө гаргагчтай гэрээ байгуулахгүйгээр цахим мөнгөний үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээд байна.

Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх

3.5 Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 2.1 болон 2.3-т заасан шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

3.5.1 Банк, цахим мөнгө гаргагчаас бусад этгээд хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг өөр дээрээ байршуулахгүй байх;

3.5.2 Хэрэглэгчийн данс байршиж буй этгээдтэй нууцлалын өндөр түвшинд, бусад этгээд нэвтрэх боломжгүй сувгаар холбогдох техникийн бүтэц, зохион байгуулалттай байх;

3.5.3 Хэрэглэгчийн дансыг өөр дээрээ байршуулж буй гуравдагч этгээд рүү холбогдож гүйлгээ үүсгэх үед эрх бүхий этгээдээс бусад этгээд гүйлгээ үүсгэх боломжгүй байх нөхцлийг хангасан байх.

3.5.4 Дараах үйл ажиллагааг тусгасан баримт бичигтэй байх. Үүнд:

3.5.4.1 Хэрэглэгчийн данс байршиж буй гуравдагч этгээд, хэрэглэгч, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, тэдгээрийн хооронд үүсэх маргааны зохицуулалт;

3.5.4.2 Хэрэглэгчийн данс байршиж буй этгээдтэй холбогдон ажиллах мэдээллийн технологийн шийдэл, ажиллах зарчим, мэдээллийн нууцлал, хадгалалт, дамжуулалт, боловсруулалтын талаарх дэлгэрэнгүй зохицуулалт;

3.5.4.3 Хэрэглэгчээс тухайн үйлчилгээг авахыг зөвшөөрүүлэх үйл ажиллагаа

Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагч

3.6 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллана. Энэ заалтад гэрээт төлөөлөгч хамаарахгүй.

3.7 Оператор нь аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллана.

3.8 Монголбанк нь тухайн этгээдэд аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ дараах нөхцлийг шаардана:

3.8.1 Аутсорсингийн үйлчилгээ авч буй этгээд нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлж буй этгээдэд шалгуур үзүүлэлт тавьж, хянадаг байх, шаардлагатай мэдээлэлд цаг алдалгүй хандах боломжтой байх;

- 3.8.2 Аутсорсингийн үйлчилгээ авснаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, операторын дотоод хяналтын үйл ажиллагаа хязгаарлагдахгүй байх;
- 3.8.3 Аутсорсингийн үйлчилгээ авснаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, операторын энэ журамд заасан шаардлагыг хангаж буй эсэхэд Монголбанкны тавих хяналт хязгаарлагдахгүй байх;
- 3.8.4 Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдал алдагдахгүй байх;
- 3.8.5 Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагчийн удирдлагын үүрэг хариуцлага шилжихгүй байх;
- 3.8.6 Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагчийн хэрэглэгчийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, тэдгээрийн хоорондын харилцаанд нөлөөлөхгүй байх;
- 3.8.7 Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагч нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд энэ журамд заасан шаардлагыг тавьж, хэрэгжилтийг хянах, шаардлагатай мэдээлэлд цаг алдалгүй хандах боломжтой байх нөхцлийг бүрдүүлсэн байх;
- 3.9 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор нь аутсорсингийн үйлчилгээ авснаар энэ журмын нөхцөл, шаардлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 3.10 Аутсорсингийн үйлчилгээ үзүүлж буй этгээдийн мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдал болон санхүүгийн хариуцлагыг аутсорсингийн үйлчилгээ авч буй этгээд хариуцна.

Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч

- 3.11 Гэрээт төлөөлөгч нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн өмнөөс шинэ хэрэглэгч бүртгэх, шилжүүлэг хийх, данс нээх, хаах, бэлэн мөнгө хүлээн авах, бэлэн мөнгө олгох, гүйлгээний хуулга гаргах зэрэг үйл ажиллагааг эрхэлж болно.
- 3.12 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд энэ журмын хавсралт 5-д заасан баримт бичгийг ирүүлж Монголбанкнаас зөвшөөрөл авна.
- 3.13 Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан этгээд нь үйл ажиллагааг эхэлснээс хойш ажлын 5 өдрийн дотор тухайн гэрээт төлөөлөгчийг Монголбанканд бүртгүүлнэ.
- 3.14 Гэрээт төлөөлөгчийн үйлчилгээ үзүүлж буй этгээдийн мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдал болон санхүүгийн хариуцлагыг гэрээт төлөөлөгчөөр дамжуулан үйлчилгээ эрхэлж буй этгээд хариуцна.

ДӨРӨВ.ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ

- 4.1 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын хавсралт 1-т заасан өргөдлийг хавсралт 2-т заасан баримт бичгийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид ирүүлнэ.

- 4.2 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл эзэмшиж буй этгээд бусад төрлийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл хүсэх бол энэ журмын хавсралт 2-т заасан, зөвхөн шинээр эрхлэх гэж буй үйл ажиллагаатай холбогдон үүсэх өөрчлөлтийг тусгасан баримт бичгийг энэ журмын хавсралт 1-т заасан өргөдлийн хамт ирүүлнэ.
- 4.3 Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын хавсралт 3-т заасан баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ.
- 4.4 Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч банк нь энэ журмын хавсралт 4-т заасан баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ.
- 4.5 Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргач нь энэ журмын хавсралт 5-д заасан баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ.
- 4.6 Хүсэлт гаргагч нь материал ирүүлэхээс өмнө Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу зөвшөөрлийн материал хүлээж авах хураамжийг төлнө.

ТАВ.ХҮСЭЛТИЙГ СУДЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОСОН ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ

- 5.1 Монголбанк нь зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн ирүүлсэн баримт бичгийг судалж, тухайн хүсэлт гаргагч нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан эсэх, ирүүлсэн баримт бичгийн бүрдэл бүрэн эсэх талаар дүгнэлт, санал гаргана.
- 5.2 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1.8 болон 14.1.10-т заасны дагуу нэмэлт материал шаардаж болно.
- 5.3 Монголбанк ирүүлсэн баримт бичгийг хянаж, бүрдүүлбэр дутуу, нэмэлт материал шаардлагатай тохиолдолд 60 хоногийн дотор хүсэлт гаргагчид албан бичгээр эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 5.4 Зөвшөөрөл авах хүсэлт гаргагч Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, энэ журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж ирүүлснээс хойш Монголбанк зөвшөөрөл олгох эсэх асуудлыг 60 хоногийн дотор хянаж, шийдвэрлэнэ.
- 5.5 Монголбанкны хянан шалгагч нь зөвшөөрлийн материал шалгах явцад тухайн хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа явуулах барилга байгууламж, системд нэвтэрч тоног төхөөрөмж, програм хангамж, баримт бичиг, үйл ажиллагаатай танилцаж болно.
- 5.6 Зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, энэ журамд заасан шаардлагыг хангасан, ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангасан тохиолдолд зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 4 жилийн хугацаатай олгож, шийдвэрийг ажлын 3 хоногийн дотор албан бичгээр хүсэлт гаргагч руу хүргүүлнэ.
- 5.7 Зөвшөөрөл олгох шийдвэрт тухайн хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрлийн төрлийг тодорхой тусгана.
- 5.8 Зөвшөөрөл олгох шийдвэр гарсан тохиолдолд хүсэлт гаргагч нь Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан холбогдох зөвшөөрлийн хураамжийг төлнө.

- 5.9 Зөвшөөрөл авсан этгээд нь өөрийн эзэмшиж буй зөвшөөрлийн хугацааг сунгах бол энэ журмын 5.6-д заасан хугацаа дуусгавар болохоос 180 хоногийн өмнө зөвшөөрөл сунгах хүсэлт гаргана.
- 5.10 Зөвшөөрөл сунгах хүсэлтийг энэ журмын 4, 5, 6 дугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэж, ирүүлсэн баримт бичиг шаардлага хангасан тохиолдолд зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хугацаагүй сунгана.

ЗУРГАА.ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ, ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

- 6.1 Монголбанк дараах үндэслэлээр зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзаж, ажлын 3 хоногийн дотор хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. Үүнд:
- 6.1.1 Зөвшөөрөл авах, зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, энэ журамд заасан шаардлагыг хангаагүй гэж Монголбанк дүгнэсэн;
- 6.1.2 Энэ журмын 5.3-т заасны дагуу ирүүлсэн баримт бичиг шаардлага хангаагүй, бүрдэл дутуу тухай хүсэлт гаргагчид мэдэгдсэн боловч тогтоосон хугацаанд нэмэлт баримт бичгийг ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй.
- 6.2 Зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан хариу авсан этгээд хамгийн сүүлд хүсэлт гаргаснаас хойш 180 хоногийн дараа дахин зөвшөөрөл авах хүсэлт гаргаж болох бөгөөд энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн холбогдох хураамжийг дахин төлнө.
- 6.3 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.1-т заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.
- 6.4 Тухайн этгээдийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон нөхцөлд төлбөр тооцооны болон клирингийн систем дэх гүйлгээнд нь операторын зүгээс хязгаарлалт тогтооно.
- 6.5 Энэ журмын 6.3-т заасан зөрчлийг арилгасныг Монголбанкнаас тогтоовол холбогдох шийдвэрийг үндэслэж зөвшөөрлийг сэргээнэ.
- 6.6 Зөвшөөрлийг сэргээхдээ түдгэлзүүлсэн хугацааг нөхөн олгохгүй.
- 6.7 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.2-т заасан үндэслэлээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 6.8 Хүчингүй болсон зөвшөөрлийг дахин олгох тухай хүсэлтийг Монголбанк тухайн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын хугацаанд хүлээн авахгүй бөгөөд хүсэлт гаргагч нь тогтоосон хугацааны дараа энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн хүсэлт гаргана.
- 6.9 Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгосон тохиолдолд тухайн этгээд нь өөрийн үйл ажиллагааг Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн зогсоож, хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу хэрэглэгч, мерчантын хохирлыг барагдуулах, мөнгөн хөрөнгийг буцаан олгох арга хэмжээг авна.

- 6.10 Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгох нь хэрэглэгч, мерчантын хохирлыг барагдуулах зорилгоор мөнгөн хөрөнгийг буцаан олгохгүй байх үндэслэл болохгүй.
- 6.11 Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авахтай холбогдон гарсан зардлыг тухайн хуулийн этгээд хариуцна.
- 6.12 Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох тухай Монголбанкны шийдвэрийн эсрэг зөвшөөрөл эзэмшигч 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдол гаргасан нь Монголбанкны шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

ДОЛОО. ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

- 7.1 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгч (энэ журмын 3.4.11-т зааснаас бусад), клирингийн төв, гэрээт төлөөлөгч, аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөр тооцооны төлөөлөгч, мерчанттай хамтран ажиллахдаа талуудын эрх үүргийг тодорхой тусгасан гэрээ байгуулна.
- 7.2 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн оролцож буй системийн дүрэм, стандартыг дагаж мөрдөнө.
- 7.3 Үйлчилгээний нөхцөл, түүний ил тод байдлыг хангах, хэрэглэгчийг хамгаалах талаар Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.
- 7.4 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, системийн дүрэм, хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрэглэгчээс төлбөр тооцоо хийх зорилгоор байршуулсан мөнгөн хөрөнгийг тухайн хэрэглэгчийн анхны шаардлагаар гаргаж өгнө.
- 7.5 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, системийн дүрэм, хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрэглэгчийн төлбөрийг саатуулж үл болно.
- 7.6 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, системийн дүрэм, хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд гүйлгээг хүлээн авсан даруй төлбөр хүлээн авагчийн дансанд тусгана.
- 7.7 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, системийн дүрэм, хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрэглэгчийн хувийн болон гүйлгээний мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй, хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй.
- 7.8 Хэрэглэгчээс гаргасан гомдол, маргаан, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн тухай бүртгэл, хэрэглэгчийн гүйлгээний цахим мэдээг тухайн гүйлгээ үүссэн өдрөөс эхлэн хамгийн багадаа 5-аас доошгүй жил тус тус хадгална.
- 7.9 Гэрээ болон хуульд өөрөөр заагаагүй бол хэрэглэгчийн зөвшөөрөл, баталгаажуулалтгүйгээр данснаас зарлагын гүйлгээ хийхийг хориглоно.
- 7.10 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, түүний гэрээт төлөөлөгч нь тухайн гүйлгээг эрх олгогдоогүй этгээд үүсгэсэн, хууль бус, сэжиг бүхий гүйлгээ гэж үзсэн, энэ журмын 2.1.10.4, 2.1.10.5-д

заасан нөхцөл байдал үүссэн даруй гүйлгээний эрхийг тухайн нөхцөл байдал арилах хүртэлх хугацаагаар хааж, цаашид гарч болох эрсдэлээс хамгаална.

- 7.11 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн системд гэмтэл, саатал үүсч хэрэглэгчийн төлбөр саатах тохиолдолд нөхцөл байдлын талаар тухай бүр хэрэглэгчдэд мэдэгдэж, саатлыг хурдан хугацаанд засч, үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах арга хэмжээг авна.
- 7.12 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний нөхцөл, хөлс, шимтгэл, хураамжид өөрчлөлт оруулах бол хэрэглэгчид урьдчилж мэдэгдэнэ.
- 7.13 Хэрэглэгчид олгох нууц үг, бусад нууцлах шаардлагатай мэдээллийг битүүмжилсэн байдлаар хүлээлгэн өгөх эсхүл хэрэглэгчээс бусад этгээд олж мэдэх боломжгүй байх нөхцлийг хангасан байна.
- 7.14 Хэрэглэгч тухайн төлбөрийн хэрэгсэл, түүнтэй холбоотой нууц үг, гүйлгээ үүсгэхэд ашиглагдах бусад мэдээллийг гэж үрэгдүүлэх, бусдад алдах тохиолдолд гарч болох эрсдэлийн талаар болон хууран мэхлэх, залилангийн шинжтэй гүйлгээнээс хэрхэн сэргийлэх талаар хэрэглэгчийг мэдээллээр хангана.
- 7.15 Хэрэглэгчийн хийж буй санхүүгийн болон санхүүгийн бус аливаа гүйлгээнээс шимтгэл авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 26.4-т заасны дагуу гүйлгээ хийгдэхээс өмнө шимтгэлийн дүн, тайлбарыг тодорхой харуулна.
- 7.16 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн хаяг өөрчлөгдөх бүрт Монголбанканд ажлын 5 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.
- 7.17 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу гэрээт төлөөлөгч, аутсорсингоор дамжуулан үзүүлсэн төлбөрийн үйлчилгээний хариуцлагыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хүлээнэ.
- 7.18 Системд саатал, гэмтэл гарах үед мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн технологи болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтан, тэдгээрийг орлох албан тушаалтны нэрсийн жагсаалт, холбоо барих утас зэрэг мэдээллийг оролцогч, оператор нь албан ёсоор харилцан солилцох бөгөөд нэрсийн жагсаалтад өөрчлөлт орох бүрт харилцан мэдэгдэнэ.
- 7.19 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг жилд 1 (нэг) болон түүнээс дээш удаа туршина.
- 7.20 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн систем, бүтэц зохион байгуулалтад дараах өөрчлөлт хийхээс 30 хоногийн өмнө тухайн өөрчлөлттэй холбоотой саналаа Монголбанканд танилцуулж, шаардлагатай тохиолдолд дүгнэлт гаргуулна:
- 7.20.1 Зөвшөөрөлтэй эрхэлж буй үйл ажиллагааны хүрээнд шинэ технологи дээр суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхийн өмнө тухайн шинэчлэлттэй холбоотой үүссэн, анх зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичиг, гэрээ хэлцэл, техник технологи, програм хангамжид өөрчлөлт орох;
- 7.20.2 Гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх;
- 7.20.3 Аутсорсингийн үйлчилгээ үзүүлж буй этгээд болон төлбөр тооцооны төлөөлөгч өөрчлөгдөх, клирингийн болон төлбөр тооцооны системд холбогдох;
- 7.20.4 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн оноосон нэр, үйлчилгээний нэр өөрчлөгдөхөөс өмнө Монголбанкинд энэ тухайгаа хавсралт 8-д заасан маягтын дагуу

мэдэгдэх бөгөөд нэр солисноор хэрэглэгч, олон нийтийн дунд тухайн үйлчилгээтэй холбоотой төөрөгдөл үүсэх эсэх талаар Монголбанк дүгнэлт гаргасны дараа оноосон нэрийг солино.

7.21 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын 2.1 болон 2.3-т заасан шаардлагыг үргэлж биелүүлэн ажиллана.

7.22 Энэ журмыг зөрчсөнөөс үүдэн гарсан хохирлыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

Карт гаргах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл

7.23 Карт гаргагч нь энэ журмын 7.1-7.22-т заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

7.23.1 “₮ карт” гаргах тохиолдолд дотоодын цахим худалдааны эрхийг нээсэн байх;

7.23.2 Цахим худалдааны ПИН кодоор баталгаажуулсан гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцах;

7.23.3 Цахим худалдааны CVV кодоор баталгаажуулсан гүйлгээг зөвшөөрөх;

7.23.4 Өөрийн гаргах бүх чиптэй картын тохиргоог энэ журмын 7.33-т заасны дагуу тохируулах;

7.23.5 Картын чип уншуулж ПИН кодоор баталгаажуулсан, картын чип уншуулж ПИН кодоор баталгаажуулалт хийгдээгүй гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцах;

7.23.6 Чиптэй картыг зайнаас уншуулж, ПИН кодоор баталгаажуулсан гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцах;

7.23.7 Чип технологид шилжээгүй, соронзон тууз бүхий картын мэдээллийг хуулбарлаж хуурамч карт уншуулснаас үүдэн гарах эрсдэлийг хариуцах;

7.24 Карт гаргагч нь Монголбанкнаас дүгнэлт авснаар олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран “Ко-брэнд ₮ карт” гаргаж болно.

7.25 “Ко-брэнд ₮ карт”-д олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагаас олгосон БИН дугаарыг Монголбанкинд бүртгүүлснээр ашиглаж болно.

7.26 Монголбанк нь “Ко-брэнд ₮ карт”-аар хийсэн гүйлгээнээс нэмэлт шимтгэл авч болно.

Карт хүлээн авах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл

7.27 Карт хүлээн авагч нь энэ журмын 7.1-7.22-т заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

7.27.1 Карт хүлээн авах төхөөрөмжийн тохиргоог энэ журмын 7.33-т заасны дагуу тохируулах;

7.27.2 Цахим худалдааны CVV кодоор баталгаажуулсан гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцах;

7.27.3 Чиптэй картыг зайнаас уншуулж 100,000 төгрөг болон түүнээс доош дүнтэй ПИН кодоор баталгаажуулаагүй гүйлгээ хийсэн тохиолдолд гарах эрсдэлийг хариуцах;

- 7.27.4 Чиптэй картыг соронзон тууз уншуулж гүйлгээ хийснээс үүдэн гарах эрсдэлийг хариуцах;
- 7.27.5 Карт хүлээн авагч нь худалдаа, үйлчилгээ эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийг мерчантаар элсүүлэн, гэрээ байгуулна;
- 7.27.6 Карт хүлээн авагч нь энэ журмын 7.27.3-т заасан мөнгөн дүнгийн хязгаар дотор баталгаажуулалт шаардах гүйлгээний мөнгөн дүнгийн хязгаарыг өөрөө тогтооно;
- 7.27.7 Энэ журмын 7.31-д зааснаас бусад тохиолдолд 7.28-д заасан шимтгэлийг карт эзэмшигчээс авахыг хориглоно;
- 7.27.8 ПОС төхөөрөмжийг карт уншуулах үеэс эхлэн карт гаргагчаас тухайн гүйлгээг хүлээн зөвшөөрсөн цахим мэдээг хүлээн авах хүртэлх үе шат бүрт 30 (гучин) секундээс илүү хугацаа зарцуулах нөхцөлд автоматаар анхны төлөвт шилжиж, дараагийн картыг хүлээн авахад бэлэн байхаар тохируулна;
- 7.27.9 ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгө авах гүйлгээг¹ зөвхөн худалдан авалттай цуг хийнэ;
- 7.27.10 ПОС төхөөрөмжийн тохиргоонд тухайн мерчантын үйл ажиллагааны ангиллын кодыг² энэ журмын хавсралт 10-т заасны дагуу бүртгэнэ.
- 7.28 Бараа, үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авсан тохиолдолд карт хүлээн авагчийн авах шимтгэлийн дээд хязгаар нь 3 хувь, доод хязгаар нь 1 хувь байна.
- 7.29 АТМ төхөөрөмж ашиглан бэлэн мөнгө авах гүйлгээний шимтгэлийн хэмжээг 500 (таван зуун) төгрөгөөс дээшгүй байхаар тогтоох ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.
- 7.30 ПОБ болон ПОС төхөөрөмж ашиглан 1,000,000 (нэг сая) төгрөг хүртэлх дүнтэй бэлэн мөнгө авахад (cashback) шимтгэлийн хэмжээ нь 500 (таван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.
- 7.31 Төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөрийг картаар хүлээн авсны шимтгэл нь 300 (гурван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.

Карт гаргагч, хүлээн авагчийн нийтлэг эрх, үүрэг

- 7.32 Картаар хийх дараах төрлийн гүйлгээнд баталгаажуулалт шаардахгүй байж болно:
- 7.32.1 Картын соронзон туузыг уншуулсан 10,000(арван мянган) төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ;
- 7.32.2 Картын чипийг зайнаас уншуулсан 100,000(зуун мянган) төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ.
- 7.33 Карт гаргагч, хүлээн авагч нь гүйлгээнд дараах байдлаар баталгаажуулалт шаардана:
- 7.33.1 Картын соронзон туузыг уншуулсан 10,000(арван мянган) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг ПИН кодоор;

¹ cashback гүйлгээ

² Merchant category code

- 7.33.2 Цахим худалдааны гүйлгээг ПИН код эсвэл CVV кодоор;
- 7.33.3 Ухаалаг гар утасны тусламжтайгаар, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч буюу МПОС төхөөрөмжийн гүйлгээг гарын үсгээр;
- 7.33.4 Картын чипийг зайнаас уншуулсан 100,000(зуун мянган) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг ПИН кодоор;
- 7.33.5 Картын чип уншуулсан гүйлгээг ПИН кодоор.
- 7.33.6 Картын чипийг дээд тал нь 20(хорин) удаа дараалан зайнаас уншуулж баталгаажуулалтгүй гүйлгээ хийсний дараа чип уншуулж ПИН кодоор баталгаажуулна.

7.34 Карт гаргагч, хүлээн авагч нь шимтгэлийг дараах байдлаар хуваана:

- 7.34.1 Карт хүлээн авагч нь мерчант-д хийгдсэн гүйлгээний үнийн дүнгийн 0.3 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлнө (Төрийн үйлчилгээ, орон сууцны хэрэглээний төлбөр төлөх гүйлгээнээс бусад);

Цахим мөнгө гаргах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл

7.35 Цахим мөнгө гаргагч нь энэ журмын 7.1-7.22-т заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 7.35.1 Хэрэглэгчийн анхны шаардлагаар цахим мөнгө болон төгрөгийг харилцан хөрвүүлэх;
- 7.35.2 Цахим мөнгө гаргахад хэрэглэгчээс хүлээн авсан мөнгөн хөрөнгийг 100 (зуун) хувь баталгааны дансанд байршуулах;
- 7.35.3 Баталгааны данс өөрчлөгдөх бүрт Монголбанканд ажлын 3 хоногт багтаан мэдэгдэх;
- 7.35.4 Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгө нь эргэлтэд гарсан нийт цахим мөнгөнөөс дутвал дараагийн ажлын өдөрт багтаан нөхөх;
- 7.35.5 Баталгааны дансанд зөвхөн цахим мөнгө болон төгрөгийг харилцан хөрвүүлэхтэй холбоотой гүйлгээ болон түүний шимтгэлийн гүйлгээг хийх;
- 7.35.6 Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг зээлийн эх үүсвэр болгон ашиглах, хөрөнгө оруулах зэрэг өөр зорилгоор ашиглах, барьцаа хөрөнгө болгохыг хориглох;
- 7.35.7 Цахим мөнгө гаргагч нь дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсон, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг зөвхөн хэрэглэгчийн цахим мөнгийг мөнгөн хөрөнгөд хөрвүүлэх зорилгоор ашиглах;
- 7.35.8 Цахим мөнгө гаргах зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 3.4-т заасан шаардлагыг үргэлж хангаж ажиллах;
- 7.35.9 Нэг цахим мөнгө нь нэг төгрөгтэй тэнцүү байна;
- 7.35.10 Цахим мөнгөнд хүү тооцохгүй;

- 7.35.11 Хэрэглэгчийн нэг удаад хийх гүйлгээний дээд хэмжээ 3,000,000 (гурван сая) төгрөг байна;
- 7.35.12 Нэг хэрэглэгчийн дансан дахь цахим мөнгөний дээд хэмжээ 20,000,000.00 (хорин сая) төгрөгөөс хэтрэхгүй;
- 7.35.13 Бүртгэлгүй хэрэглэгчийн нэг өдөрт хийх гүйлгээний дээд хязгаар 20,000.00 (хорин мянга) төгрөг байна;
- 7.35.14 Бүртгэлгүй хэрэглэгчийн дансан дахь цахим мөнгөний дээд хэмжээ 100,000.00 (нэг зуун мянга) төгрөг байна.

**Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл
эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл**

- 7.36 Төлбөр тооцооны төлөөлөгч нь энэ журмын 7.1-7.22-т заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 7.36.1 Монголбанк болон шууд бус оролцогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн шууд бус оролцогчийн төлбөр тооцоог өөрийн Монголбанкна дахь дансаар гүйцэтгэх;
- 7.36.2 Оролцогчтой төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ байгуулах;
- 7.36.3 Шууд бус оролцогчоос төлбөр тооцооны зорилгоор байршуулсан мөнгөн хөрөнгийг зөвхөн үр дүнгийн төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор ашиглах;
- 7.36.4 Төлбөр тооцооны төлөөлөгч нь шууд бус оролцогчийн төлбөр тооцоо найдвартай гүйцэтгэх нөхцөлийг хангаж ажиллах;
- 7.36.5 Шууд бус оролцогч нарт ижил хөлс, хураамж, шимтгэл ногдуулж, үйлчилгээ авах эрх тэгш боломжоор хангах.

**НАЙМ.СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН
ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

- 8.1 Монголбанкны ажиллуулж буй клирингийн болон төлбөр тооцооны системийг хариуцаж буй нэгж, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд нь /Цаашид оператор гэх/ дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 8.1.1 Оператор нь тухайн системийн оролцогчтой болон Монголбанктай хамтран ажиллах гэрээ байгуулна (Оператор нь Монголбанк байх тохиолдолд зөвхөн оролцогчтой гэрээ байгуулна);
- 8.1.2 Оператор нь өөрийн системийн дүрэмд заасны дагуу гүйлгээний боловсруулалт, дамжуулалтыг тасралтгүй хийж, гүйцэтгэнэ;
- 8.1.3 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчтай техникийн туршилт хийж, холбогдох дүгнэлтийг зөвшөөрөл хянан шийдвэрлэх хугацаанд багтаан гаргана;
- 8.1.4 Оролцогч хоорондын гүйлгээний үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг “Банксүлжээ” системд ажлын өдөр бүр 1(нэг) болон түүнээс дээш удаа боловсруулж, илгээнэ;

- 8.1.5 Оператор нь өөрийн системийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллана;
- 8.1.6 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу аутсорсингоор дамжуулан үзүүлсэн үйлчилгээний хариуцлагыг оператор хүлээнэ;
- 8.1.7 Оператор нь өөрийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг жилд 1 (нэг) болон түүнээс дээш удаа бүх оролцогчдыг хамруулан туршиж, шаардлагатай өөрчлөлтийг тухай бүрт нь оруулж ажиллана;
- 8.1.8 Операторын мэдээллийн технологийн системд том хэмжээний өөрчлөлт хийгдэх, оролцогчдыг хамарсан туршилт хийх, гэнэтийн саатал гэх мэт төлбөрийн системд нөлөөлж болохуйц ажиллагааны явцад Монголбанкны хянан шалгагч хяналт тавина;
- 8.1.9 Операторын системд гэнэтийн саатал гарсан тохиолдолд саатлын талаар системийн оролцогчдод нэн даруй мэдэгдэж, засварлах хугацаа, авах арга хэмжээний талаар мэдээлэл өгч, саатлыг богино хугацаанд арилгах, системийг хэвийн байдалд оруулах бүх арга хэмжээг авна. Шаардлагатай тохиолдолд оролцогчтой хамтран ажиллана;
- 8.1.10 Системд саатал, гэмтэл гарах үед мэдээлэл солилцох зорилгоор дундын цахим групп үүсгэсэн байх бөгөөд оролцогч болон операторын холбогдох албан тушаалтан солигдсон эсэхээс үл хамааран мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ;
- 8.1.11 Мэдээллийн технологи болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтан, тэдгээрийг орлох албан тушаалтны нэрсийн жагсаалт, холбоо барих утас зэрэг мэдээллийг оператор болон оролцогч нь харилцан солилцох бөгөөд нэрсийн жагсаалтад өөрчлөлт орох бүрт харилцан мэдэгдэнэ;
- 8.1.12 Оператор нь өөрийн хариуцан ажиллуулж буй систем болон системийн дүрэмд өөрчлөлт оруулахаас ажлын 21-ээс доошгүй өдрийн өмнө нийт оролцогч нарт албан ёсоор мэдэгдэж, холбогдох зааврыг хүргүүлнэ;
- 8.1.13 Оператор нь энэ журмын 8.1.12-т заасан өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс өмнө оролцогчид ба харилцан холболт бүхий операторуудтай хамтарсан туршилт хийж, хяналт тавина. Шаардлагатай гэж үзвэл туршилтын явцад операторын зүгээс оролцогч болон харилцан холболт бүхий оператор нарт туслалцаа үзүүлнэ;
- 8.1.14 Системийн дүрэм, үйлчилгээний болон шимтгэл, хураамжийн нөхцлийг өөрийн цахим хуудсанд нийтэд ил тод байршуулна;
- 8.1.15 Монголбанкны шийдвэрийн дагуу өөрийн системийн оролцогчийн гүйлгээнд хязгаарлалт тогтоох, гүйлгээг нь дамжуулахгүй байх арга хэмжээг авна.
- 8.2 Монголбанкны ажиллуулж буй системийг хариуцсан нэгж нь энэ журмын 8.1-т заасан үүргийг өөрийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллана.

ЕС. ИННОВАЦИЙН ОФФИС

- 9.1 Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор баталсан аливаа журам, заавар, дүрмийн талаар хуулийн этгээдэд мэдээлэл өгөх, санал хүсэлтийг хүлээн авах үүрэг бүхий инновацийн оффисыг Монголбанкны төлбөрийн системийг хариуцсан газар, нэгжээс хариуцан ажиллуулна.

9.2 Инновацийн оффис нь дараах чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгнө. Үүнд:

9.2.1 Шинэлэг санаа, инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Монголбанкнаас баталсан журам зааврыг хэрхэн хамааруулж ойлгох, ашиглах, мөрдөх;

9.2.2 Тухайн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхэд журам зааврын хүрээнд тулгарч буй бэрхшээл, хязгаарлалт тогтоож буй зүйл заалтын талаар мэдээлэл солилцох.

9.3 Инновацийн оффис нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан болон аваагүй бүх хуулийн этгээд, тэдгээрийн төлөөлөгч нарт нээлттэй бөгөөд санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээ нь шинэлэг санаа, инновац дээр суурилсан байх үндсэн шаардлагыг тавина.

9.4 Инновацийн оффист хандах этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

9.4.1 Санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь шинэлэг санаа, инновац дээр суурилсан байх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх;

9.4.2 Үйлчилгээ нь санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлд ашиглагдах зорилго агуулаагүй байх;

9.4.3 Ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад хэрэглэгчдийн хүртэх үр ашиг, өрсөлдөх чадвараар илүү байх;

9.4.4 Хүсэлт гаргагч нь төлбөрийн системд хамаарах хууль, Монголбанкнаас баталсан журам, зааврын талаар уншиж судалсан байх;

9.4.5 Үйл ажиллагаа явуулахад үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлж, сэргийлэх арга хэрэгслийг бий болгосон байх.

9.5 Технологийн шийдэл нь зах зээлд нэвтэрсэн, эсхүл хэрэглэгчдэд хүргэх үр ашиг багатай, энэ журмын 9.4-т заасан шаардлагыг хангахгүй гэж Монголбанкнаас үзвэл тухайн этгээдийг инновацийн оффист хүлээн авахгүй.

АРАВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, ТАЙЛАН МЭДЭЭ

Хяналт

10.1 Монголбанк нь төлбөрийн системийн үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

10.2 Монголбанк нь төлбөрийн системд дараах үндсэн чиглэлээр хяналт тавина:

10.2.1 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, журам, тушаал, дүрэм, заавар, гэрээ, Монголбанкнаас тавигдсан шаардлагын дагуу явагдаж буй эсэх;

10.2.2 Монголбанкнаас үүсгэн байгуулж, ажиллуулж буй системийн оператор нь энэ журам, оролцогчтой байгуулсан гэрээ болон Монголбанкнаас баталсан төлбөрийн системд мөрдөх бусад эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж буй эсэх.

- 10.3 Монголбанк нь үндэсний төлбөрийн системийн оролцогч болон операторын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхдээ хянан зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагатай хамтарч болно.
- 10.4 Монголбанк нь газар дээрх хяналт, шалгалтыг урьдчилан төлөвлөсний дагуу (төлөвлөгөөт) болон гэнэтийн хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- 10.5 Төлөвлөгөөт шалгалтыг оролцогчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр хийнэ.
- 10.6 Хянан шалгагч нь тодорхой мэдээлэлд үндэслэн Монголбанкны холбогдох удирдлагад танилцуулсны үндсэн дээр, эсхүл удирдлага, газрын захирлын өгсөн үүрэг даалгавар, удирдамжийн дагуу гэнэтийн шалгалтыг оролцогчид урьдчилан мэдэгдэлгүйгээр хийж болно.
- 10.7 Шалгалтыг хамрах хүрээгээр нь иж бүрэн ба хэсэгчилсэн гэж ангилна.
- 10.7.1 Иж бүрэн шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан хуваарь, удирдамжийн хүрээнд хийх ба оролцогчийн төлбөрийн системтэй холбоотой үйл ажиллагааг бүхэлд нь шалгаж, дүгнэлт өгнө.
- 10.7.2 Хэсэгчилсэн шалгалтыг оролцогч, хувь хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр эсхүл Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн оролцогчийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг шалгаж, дүгнэлт өгөх зорилгоор хийнэ.
- 10.8 Хянан шалгагч нь тухайн хяналт шалгалтыг хийж дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор шалгалтын тайланг бэлтгэж, цаашид хийх шаардлагатай ажил, авах арга хэмжээний талаарх саналын хамт Монголбанкны удирдлагад танилцуулах бөгөөд шалгалтын тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
- 10.8.1 Шалгалтын зорилго, хэлбэр, хамрах хүрээ, чиглэл, шалгалт хийсэн огноо;
- 10.8.2 Шалгалтын явцад илэрсэн зөрчилтэй үйл ажиллагаа, зөрчил гаргасан этгээдийн нэр, албан тушаал, зөрчигдсөн хууль тогтоомжийн заалт;
- 10.8.3 Шалгалтын ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмж;
- 10.8.4 Хууль тогтоомж зөрчсөнийг нотлох баримт материалд үндэслэн ногдуулсан Улсын байцаагчийн акт, мэдэгдэл, шийтгэвэр;
- 10.8.5 Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, засаж залруулах талаар шуурхай арга хэмжээ авсан бол тайлбар;
- 10.8.6 Шалгалтын явцад санал, гомдол хүлээн авсан бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбар;
- 10.8.7 Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар нотлох баримт бүхий тайлбар, дүгнэлт.
- 10.9 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд Монголбанкны ахлах хянан шалгагч, хянан шалгагч нь улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох арга хэмжээ авна.

- 10.10 Иргэн, хуулийн этгээд, төлбөрийн системийн оролцогч нь төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой аливаа санал, гомдлыг Монголбанканд гаргаж болно.
- 10.11 Монголбанкны хянан шалгагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийн мэдээллийн санд нэвтрэх данс, гүйлгээ, бүртгэлтэй танилцах, бусад баримт бичиг, төлбөрийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шалгах эрхтэй бөгөөд, тухайн байгууллагын ажилтнаас мэдээлэл авч болно.
- 10.12 Хяналт шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд эсхүл гомдол мэдээллийн дагуу Монголбанкны хянан шалгагч нь зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.
- 10.13 Монголбанкны хянан шалгагч нь гэрээт төлөөлөгч болон аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгчийн орон байр, тоног төхөөрөмж, програм хангамж, үйл ажиллагаатай танилцаж болно.
- 10.14 Монголбанкны хянан шалгагч хуулиар эрх олгогдсон этгээдээс бусад этгээдэд хяналт шалгалтын явцад олж авсан мэдээллийг дамжуулахгүй.
- 10.15 Монголбанкнаас шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлнэ.
- 10.16 Зөвшөөрөл бүхий этгээд нь Монголбанкнаас шаардсан тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 28.5-д заасны дагуу Монголбанканд бүртгэлтэй хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар аудит хийлгэнэ. Энэ нь тухайн байгууллагын жил тутам хийлгэдэг санхүүгийн аудитад хамааралгүй бөгөөд зөвхөн Монголбанкнаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухай байгууллагын үйл ажиллагаанд хийгдэх аудитыг ойлгоно.
- 10.17 Журмын 10.16-д заасан аудит хийлгэхтэй холбогдон гарах бүх зардлыг тухайн этгээд бүрэн хариуцна.

Тайлан мэдээ

- 10.18 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, системийн оператор нь өөрийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарч Монголбанкнаас баталсан “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын дагуу тайлан мэдээг Монголбанкны тайлангийн системд оруулж, холбогдох баталгааны маягтыг (Хавсралт 9)-ийг Монголбанкинд ирүүлнэ.
- 10.19 Цахим мөнгө гаргах зөвшөөрөл бүхий этгээд нь баталгааны дансны мэдээллийг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын хүснэгт 17-д заасны дагуу 7 хоног бүр гаргаж дараагийн Лхагва гарагт, хэрэглэгч болон гүйлгээний тайланг тус зааврын хүснэгт 18, 19-т заасны дагуу сар тутам гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкны тайлангийн системд тус тус оруулж, тайлангийн баталгааны маягтыг дараа улирлын эхний сарын 25-ны дотор Монголбанканд албан бичгээр, цахим мөнгөний баталгааны дансны өдөр тутмын үлдэгдлийг (улирлаар) банкаар баталгаажуулж, дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор эсхүл тухайн өдөр нь нийтээр амрах өдөр байх тохиолдолд дараагийн ажлын өдөр Монголбанканд албан бичгээр ирүүлнэ.
- 10.20 Картын үйл ажиллагаа эрхлэх этгээд нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 1, 2, 3, 4, 6- д заасан тайланг сар тутам гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлангийн баталгааны маягтыг дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр ирүүлнэ;

- 10.21 Банк нь мобайл болон интернет гүйлгээний тайланг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 7, 8, 9, 10-т заасны дагуу, төлбөрийн картаас бусад хэрэгсэл ашиглан банкны салбар дээр хийгдсэн гүйлгээний тоон мэдээг Хүснэгт 5-д заасны дагуу сар тутам гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлан баталгаажуулах маягтыг дараа сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр ирүүлнэ.
- 10.22 Оператор нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 11, 12, 13, 14-т заасны дагуу өөрийн үйл ажиллагааны тайланг сар бүр гаргаж, Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлан баталгаажуулах маягтыг дараа сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр ирүүлнэ.
- 10.23 Төлбөр тооцооны төлөөлөгч нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 15, 16-д заасны дагуу өөрийн үйл ажиллагааны тайланг сар бүр гаргаж, Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлангийн баталгааны маягтыг дараа сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр ирүүлнэ.
- 10.24 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн үйлчилгээтэй холбоотой үүссэн аливаа маргааны талаарх үнэн зөв бүртгэл, тайлан хөтөлж, Монголбанкнаас шаардсан тохиолдолд тухайн мэдээллийг Монголбанкинд хүргүүлнэ.
- 10.25 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон оператор нь энэ журмын 10.18-10.24-т заасан тайлан мэдээнээс гадна өөрийн үйл ажиллагаанд хамаарах Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг тухай бүр ирүүлнэ.
- 10.26 Хууль, журамд өөрөөр заагаагүй бол Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тайлан мэдээг тухайн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор нь өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.
- 10.27 Тайланд тусгагдах гүйлгээний дүнг төгрөгөөр илэрхийлсэн байна. Төгрөгөөс бусад валютаар хийгдсэн гүйлгээний дүнг тайлант хугацааны сүүлийн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцож тайлагнана.
- 10.28 Монголбанк нь дээрх тайлан мэдээг нэгтгэж, сарын хураангүй тайлан мэдээг дараа сард, улирал тутмын тайлан мэдээг дараа улиралд багтаан тус тус олон нийтэд мэдээлнэ.

Хариуцлага

- 10.29 Энэ журмыг зөрчсөн, Монголбанкнаас гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтан, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Монголбанкны улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

_____ооо_____

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи /Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ/					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгоно уу.						
☐ Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх ☐ Карт гаргах /Картын оноосон нэрийг бичнэ/ ☐ Карт хүлээн авах /Картын оноосон нэрийг бичнэ/ ☐ Цахим мөнгө гаргах ☐ Систем ажиллуулах ☐ Төлбөр тооцооны төлөөлөгч ☐ Аутсорсингийг үйлчилгээ авах ☐ Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх						
Хуулийн этгээдийн хэлбэр	☐ Хувьцаат компани ☐ Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Хөрөнгө оруулалтын хэлбэр	☐ Дотоодын хөрөнгө оруулалттай ☐ Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг, байршил	Аймаг/Хот					
	Сум/Дүүрэг					
	Баг/Хороо					
	Гудамж/байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
	Цахим хуудас					
	Цахим хаяг					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл						
Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/оноосон нэр	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны төрөл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн /ХНХ/ хэмжээ	ХНХ-д эзлэх хувь (%)		
		☐ ДЭХ ☐ ЭХ				

		☐ ДЭХ	☐ ЭХ		
		☐ ДЭХ	☐ ЭХ		
Тэмдэглэл: ДЭХ-Давуу эрхийн хувьцаа, ЭХ-энгийн хувьцаа. /Хувьцаа эзэмшигч тус бүрээр бичнэ./					
Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.					
Хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол				
	Англи				
Улсын бүртгэлийн дугаар					
Регистрийн дугаар					
Бизнесийн болон үйл ажиллагааны чиглэл					
Хаяг байршил	Аймаг/Хот				
	Сум/Дүүрэг				
	Баг/Хороо				
	Гудамж/байр				
	Тоот				
	Холбоо барих утас				
	Цахим хуудас				
	Цахим хаяг				
Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол доорх мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.					
Овог нэр					
Регистрийн дугаар					
Албан ёсны хаяг, байршил					
Эрхэлж байгаа ажил, албан тушаал					
Ажлын хаяг					
Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл					
ТУЗ-тай байх эсэх	☐ Тийм	☐ Үгүй	Бүрэлдэ хүүний тоо		
Хяналтын зөвлөлтэй эсэх	☐ Тийм	☐ Үгүй			
Нийт ажилтан албан хаагчдын тоо					

Албан тушаал	Овог	Нэр	Харъя алал	РД	Утасны дугаар	Мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ын дарга							
ТУЗ-ын гишүүн							
Хяналтын зөвлөл болон хяналтын нэгжийн гишүүн							
Гүйцэтгэх захирал							
Ерөнхий нягтлан бодогч							

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг удирдах ажилтан тус бүрээр бичнэ.)

Дээрх үйл ажиллагааг эрхлэн явуулснаар Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн Монголбанкнаас баталсан эрх зүйн баримт бичгийн холбогдох заалт, шаардлагыг чанд биелүүлэх үүрэг хариуцлага ноогдож байгааг ухамсарлан ойлгосон бөгөөд эдгээрийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах болно.

Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх болон систем ажиллуулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлж, хүргүүлж байна. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно. Өргөдөл, материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж холбогдох зөвшөөрлийг олгож өгнө үү.

Зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг эрхэлж эхэлснээс хойш Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

Өргөдөл гаргасан:

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг

Огноо

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг

Огноо

ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Төлбөрийн үйлчилгээ эрхлэх эсхүл систем ажиллуулах тухай компани үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь (Нэг үүсгэн байгуулагчтай бол тухайн этгээдийн шийдвэр)	
2	Нэгээс илүү үүсгэн байгуулагчтай байх нөхцөлд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах гэрээ	
3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (нотариатаар баталгаажуулсан хуулбар)	
4	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьд гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ	
5	Компанийн дүрмийн эх хувь эсхүл баталгаажсан хуулбар	
6	Хувьцаа эзэмшигчдээс хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан мөнгөн хөрөнгийн орлогыг тодорхойлох баримт бичиг. Үүнд: - Хувьцаа эзэмшигч болох этгээд, тэдгээрийн холбогдох этгээд нь хуулийн этгээд бол үйл ажиллагааны сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан”; - Иргэн бол сүүлийн 3 (гурван) жилээс багагүй хугацааны цалин, орлогын тодорхойлолт, харилцагч банкны дансны хуулга, “Хувь хүний орлогын албан татварын тайлан”; - Хувьцаа эзэмшигч болох этгээд, тэдгээрийн холбогдох этгээд нь гааль, татварын өртэй эсэх талаарх эрх бүхий байгууллагын тодорхойлолт; - Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлоход шаардлагатай гэж Монголбанкнаас үзсэн бусад баримт бичиг	
7	Үйл ажиллагаа эрхлэх эхний 5 (таван) жилийн бизнес төлөвлөгөө (зорилтот зах зээл, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж буй этгээдээс ялгарах онцлог давуу тал, үйл ажиллагаанаас олох орлого/зардлын таамаглал тайлбарын хамт, өөрийн хөрөнгө болон өрийн харьцаа, ирээдүйн 5 жилийн мөнгөн урсгалын төсөөлөл),	
8	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлснийг нотлох баримт бичиг, тухайн баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагатай хэрхэн нийцэж буй тухай тайлбар	
9	Эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн аргачлал бүхий удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа, дотоод хяналт зэргийг зохицуулсан баримт бичиг, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл	

10	Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл. Үүнд: - Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын иргэний цахим үнэмлэх, боловсролын гэрчилгээ, дипломыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; - Гүйцэтгэх удирдлага, шийдвэр гаргах түвшний ажилтнууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан түүх байхгүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт; - Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, шийдвэр гаргах түвшний ажилтнууд нь зээл, батлан даалт, гааль, татвар, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт. Гүйцэтгэх удирдлагын албан тушаалд томилогдох этгээд нь гадаадын харьяалалтай иргэн бол: - Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй болохыг нотлох баримт бичиг; - Харьяалах улс оронд аливаа ял шийтгэл хүлээгээгүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг.	
11	Компани үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч хүртэлх хэлхээ холбоог нотлох баримт бичиг	
12	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд системийн оператор, хэрэглэгч, мерчант, аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгч, гэрээт төлөөлөгч, төлбөр тооцооны төлөөлөгчтэй байгуулах гэрээ эсхүл гэрээний баталгаажсан загвар Систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн хувьд системийн оролцогч, аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээ эсхүл гэрээний баталгаажсан загвар	
13	Тухайн төлбөрийн үйлчилгээнд ашиглагдах орон байр, систем, тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл, Үүнд: - Байрших байр, барилгыг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, түрээсэлж байгаа бол түрээсийн гэрээ; - Ажлын байр нь мөнгөн хөрөнгийн найдвартай байдлыг хангасан эсэхийг нотолсон баримт, харуул хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ, эсвэл харуул хамгаалалтын албатай болохыг нотлох баримт; - Ашиглаж буй програмын жагсаалт болон тэдгээрийн танилцуулга; - Сүлжээ болон програм хангамжийн бүтэц схем (хэрэглэгч болон сервер тал орсон); - Мэдээлэл технологийн хэлтсийн танилцуулга, ажилчдын чиг үүргийн хамт;	

	• Өгөгдлийн сангийн дэлгэрэнгүй мэдээлэл; • Системүүдийн хоорондоо харьцаж буй хэсгийн интерфэйсийн жагсаалт • Системийн ачаалал даах чадварын тайлан • Тасралтгүй ажиллагааг хангасан байдал • Нууцлал, аюулгүй байдал хангасан байдал Системийг худалдсан, програм хангамж нийлүүлэх, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэх, түрээслүүлсэн, засвар үйлчилгээ үзүүлэх компанитай байгуулсан гэрээ.	
14	Дараах үйл ажиллагааг тусгасан баримт бичиг. Үүнд: • Гүйлгээ хийгдэх, гүйлгээ дамжуулах дараалал; • Мөнгөн хөрөнгө, мэдээллийн урсгалын схемийг агуулсан үйл ажиллагааны зураглал; • Төлбөрийг гүйцэтгэх хугацаа; • Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх эсэх, зээлийн үйлчилгээ үзүүлэх эсэх; • Улс хоорондын гүйлгээнд оролцох эсэх. Гүйлгээний мэдээллийг боловсруулах, хадгалах явцад мэдээллийг задруулах, буруугаар ашиглах, устгах, өөрчлөх, хулгайлах, мэдээлэл алдагдахаас хамгаалсан арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлнэ)	
15	Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө (үйл ажиллагаа тасалдахад авч хэрэгжүүлэх арга хэмжээ, буцаж хэвийн ажиллагаанд орох хугацаа, нөөц төвийн талаарх мэдээлэл, ажиллах зарчим)	
16	Хэрэглэгч, оролцогчийн гомдол, санал, маргааныг хэрхэн шийдэх талаар тусгасан баримт бичиг, журам, дүрэм	
17	Оператортай туршилт хийж, бусад оролцогч хооронд гүйлгээ дамжуулах боломжтойг нотолсон дүгнэлт	
18	“Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан зөвшөөрлийн материал хүлээн авах хураамжийг төлсөн баримт;	
19	Хараат компани, охин компани, толгой компанийн талаарх мэдээлэл	
20	Систем ажиллуулах этгээдийн хувьд системийн дүрэм	
21	Карт гаргах эсхүл хүлээн авах хүсэлт гаргагчийн хувьд олон улсын картын сүлжээнд гишүүнээр элссэн бол тухайн гишүүнчлэлийг нотолсон баримт бичиг	
22	Гаргахаар төлөвлөж буй карт, эсхүл карт хүлээн авах төхөөрөмж нь олон улсын стандарт, шаардлагын дагуу тест хийж баталгаажуулсныг нотлох баримт бичиг буюу тест хийсэн байгууллагаас ирүүлсэн тайлан.	
23	Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагчийн хувьд цахим мөнгийг бүртгэх нягтлан бодох бүртгэл, цахим мөнгийг мөнгөн хөрөнгөд харилцан хөрвүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа, гүйлгээний лимитийг хэрхэн хангаж буйг тусгасан дүрэм, журам.	
24	Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагч нь баталгааны данс нээснийг нотлох баримт бичиг буюу банкны дансны тодорхойлолт.	

25	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл	
----	--	--

Хавсралт 3

АУТСОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ НЭМЭЛТ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Ирүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Аутсорсингоор гүйцэтгүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлбар, хавсралт 1-т заасан өргөдөл;	
2	Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын мэдээлэл (системийн үйл ажиллагаа, нууцлал аюулгүй байдал, хүний нөөцийн танилцуулга, байгууллагын бүтэц зохион байгуулалтын талаарх мэдээлэл);	
3	Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээний хувь, эсхүл баталгаажсан загвар	

Хавсралт 4

ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

№	Ирүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын хавсралт 1-т заасан өргөдөл	
2	Шууд бус оролцогчтой байгуулах гэрээний загвар	
3	Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог дамжуулах үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлбар, схем, зураглал	

**ГЭРЭЭТ ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ДАМЖУУЛАН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

№	Ирүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын хавсралт 1-т заасан өргөдөл	
2	Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан үзүүлэх төлбөрийн үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хүсэлт	
3	Гэрээт төлөөлөгчөөр мөрдүүлэх эрсдэлийн удирдлагын баримт бичиг. Үүнд: • Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг гэрээт төлөөлөгчийн авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам, дүрэм • Гэрээт төлөөлөгчийн үйл ажиллагааны болон мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах талаар тусгасан баримт бичиг	
4	Гэрээт төлөөлөгчтэй байгуулах гэрээний хувь, эсхүл баталгаажсан загвар	

**ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ХАЯГ, БАЙРШИЛ, ОНООСОН НЭРИЙН
ӨӨРЧЛӨЛТ БҮРТГЭХ МАЯГТ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргасан хуулийн этгээдийн нэр						
Регистрийн дугаар						
Өөрчлөгдөх мэдээллийн төрлийг сонгоно уу.						
☐ Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлт ☐ Хаяг байршлын өөрчлөлт ☐ Компанийн оноосон нэр/үйлчилгээний нэрийн өөрчлөлт						
Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах						
Өөрчлөлт орсон албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	РД	Утасны дугаар	Мэргэжил
Хаяг байршилд өөрчлөлт оруулах						
Шинэчлэгдсэн хаяг байршил	Аймаг/Хот					
	Сум/Дүүрэг					
	Баг/Хороо					
	Гудамж/байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
	Цахим хуудас					
	Цахим хаяг					

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫГ ӨӨРЧЛӨХӨД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх, томилох тухай шийдвэр	
2	Шинээр томилогдсон гүйцэтгэх удирдлагын цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
3	Гүйцэтгэх удирдлага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан түүх байхгүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт;	
4	Гүйцэтгэх удирдлага, шийдвэр гаргах түвшний ажилтнууд нь зээл, батлан даалт, гааль, татвар, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт.	

ОНООСОН НЭР ӨӨРЧЛӨХ ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Оноосон нэр, үйлчилгээний нэр өөрчлөх тухай хурлын тэмдэглэл, шийдвэр	
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас авсан хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас	
3	Дүрэмд орсон өөрчлөлт	

БАТАЛГААНЫ МАЯГТ

Тайланг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай

Дугаар

.

... он сар өдөр

/Байгууллагын нэр/

/Салбар, нэгжийн нэр/

/Албан тушаал/

/https://tailan.mongolbank.mn тайлангийн системд бүртгэгдсэн цахим шуудан/

Төлбөрийн системийн тайлан гаргах зааврын хүснэгтийг сонгож тэмдэглэнэ үү.

Хүснэгт 1, 2, 3, 4, 5, 6

Хүснэгт 7, 8, 9, 10

Хүснэгт 11, 12, 13, 14

Хүснэгт 15, 16

Хүснэгт 18, 19

Тайланг цахим системд үүсгэсэн огноо: 0000-сс-өө

Тайлангийн баталгааны маягтыг хүлээн авч, цахим системд баталгаажуулсан огноо: 0000-сс-өө
цц:мм:сс

..... /эцэг, эх-ийн нэр/ /нэр/ миний бие Монголбанкнаас баталсан “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх болон систем ажиллуулах үйл жиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын 10 дугаар хэсэгт заасны дагуу хуудас бүхий тайланг Монголбанкны тайлангийн системд (https://tailan.mongolbank.mn) бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлснээ баталж байна. Тайлан мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвөл хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ

Баталгаа гаргасан,

/Овог, нэр/

/Гарын үсэг/

МЕРЧАНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛЛЫН КОД

742	Мал эмнэлгийн үйлчилгээ
763	Хөдөө аж ахуйн нэгдэл
780	Орчны тохижилтын үйлчилгээ
1520	Ердийн гэрээт ажилчид
1711	Халаалт, сантехник, агааржуулалт
1731	Цахилгаан техник
1740	Чулуун буюу тоосгон өрлөг, засал чимэглэлийн үйлчилгээ
1750	Мужаан, дархан
1761	Дээврийн ажил
1771	Бетон зуурмагийн ажил
1799	Бусад үйлчилгээний гэрээт ажилчид
2741	Төрөл бүрийн хэвлэх, хувилах үйлчилгээ
2791	Үсэг өрөх, хэв бэлдэх үйлчилгээ
2842	Цэвэрлэгээ үйлчилгээ
4011	Төмөр замын ачаа тээвэр
4112	Төмөр замын зорчигч тээвэр
4119	Түргэн тусламжийн үйлчилгээ
4121	Такси, дуудлагын үйлчилгээ
4131	Автобусны шугамын үйлчилгээ
4214	Том оврын ачааны машины үйлчилгээ - хол болон ойрын зайн нүүлгэлт, хүргэлтийн үйлчилгээ
4215	Шуудангийн үйлчилгээ
4225	Агуулах болон хадгалалтын үйлчилгээ
4511	Агаарын ачаа болон зорчигч тээвэр
4582	Нисэх буудал, нислэгийн талбай
4722	Аялал жуулчлалын үйл ажиллагаа
4784	Зам, гүүрний хураамж
4789	Бусад тээврийн үйлчилгээ

4812	Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн төрөлжсөн худалдаа
4814	Харилцаа холбооны үйлчилгээ
4816	Компьютер, сүлжээний үйлчилгээ
4821	Цахилгаан холбооны үйлчилгээ
4899	Кабель, сансрын хиймэл дагуулаар телевизийн шууд нэвтрүүлэг дамжуулалт болон бусад төлбөртэй зурагт, радио
5013	Машин, сэлбэгийн нийлүүлэлт
5021	Албан байгууллага, оффисын тавилга
5039	Барилгын материалын нийлүүлэлт
5044	Гэрэл зураг хэвлэх, хувилах тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн нийлүүлэлт
5045	Компьютер, түүний дагалдах хэрэгсэл, програм хангамжийн төрөлжсөн нийлүүлэлт
5046	Бусад үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт
5047	Эрүүл мэнд, шүд, нүд болон эмнэлгийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн нийлүүлэлт
5065	Цахилгааны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн нийлүүлэлт
5072	Техник хэрэгсэл, дагалдах хэрэгслийн нийлүүлэлт
5074	Сантехник, дулааны шугам сүлжээний тоноглол, дагалдах хэрэгслийн нийлүүлэлт
5085	Бусад үйлдвэрлэлийн бараа нийлүүлэлт
5094	Үнэт чулуу, метал, цаг, үнэт эдлэлийн нийлүүлэлт
5099	Бусад удаан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүний худалдаа
5111	Бичиг хэрэг, оффисын хангамж, бичгийн болон хэвлэлийн цаасны нийлүүлэлт
5122	Эм, эмийн бүтээгдэхүүн, эрүүл мэндийн жижиг хэрэгслийн нийлүүлэлт
5131	Төрөлжсөн бус барааны нийлүүлэлт
5137	Дүрэмт хувцас, ажлын хувцасны нийлүүлэлт
5139	Гутлын ханган нийлүүлэлт
5169	Химийн бодис, бусад холбогдох бүтээгдэхүүний нийлүүлэлт
5172	Газрын тос, холбогдох бүтээгдэхүүний нийлүүлэлт
5192	Ном, сонин, сэтгүүл болон хэвлэлийн нийлүүлэлт
5193	Цэцэг, цэцгийн хэрэгслийн нийлүүлэлт

5198	Будаг, лак, орлох бүтээгдэхүүний нийлүүлэлт
5199	Богино хугацаанд хэрэглэгдэх бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт
5200	Гэр ахуйн барааны дэлгүүр
5211	Модон эдлэл, барилгын материалын дэлгүүр
5231	Шил, будаг, ханын цаасны дэлгүүр
5251	Техник хэрэгслийн дэлгүүр
5261	Зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлтийн барааны дэлгүүр
5300	Бөөний худалдаа
5309	Татваргүй барааны дэлгүүр
5310	Хямдралтай барааны дэлгүүр
5311	Их дэлгүүр
5331	Төрөлжсөн бус барааны дэлгүүр
5399	Бусад бараа бүтээгдэхүүний худалдаа
5411	Хүнсний дэлгүүр, супермаркет
5422	Мах, махан бүтээгдэхүүний нийлүүлэлт
5441	Чихэр, самар, амттаны дэлгүүр
5451	Сүү, сүүн бүтээгдэхүүний дэлгүүр
5462	Нарийн боовны газар
5499	Төрөл бүрийн хүнсний цэгүүд /ТҮЦ/
5511	Шинэ болон хуучин моторт тээврийн хэрэгслийн худалдаа, үйлчилгээ, сэлбэг болон түрээс
5521	Хуучин моторт тээврийн хэрэгслийн худалдаа, үйлчилгээ, сэлбэг болон түрээс
5531	Автомашин болон гэр ахуйн барааны дэлгүүр
5532	Автомашины дугуйны дэлгүүр
5533	Автомашины сэлбэг, жижиг хэрэгслийн дэлгүүр
5541	Автомашины үйлчилгээний цэгүүд
5542	Шатахуун түгээх газар
5561	Мотоциклийн дэлгүүр, худалдаа
5592	Зөөврийн сууцны худалдаа
5599	Бусад машин, тоног төхөөрөмжийн худалдаа

5611	Эрэгтэйчүүдийн хувцас, хэрэглэлийн төрөлжсөн дэлгүүр
5621	Эмэгтэйчүүдийн хувцасны төрөлжсөн дэлгүүр
5631	Эмэгтэйчүүдийн гоёл чимэглэл, эдлэл хэрэглэлийн дэлгүүр
5641	Хүүхэд болон нярайн хувцас хэрэглэлийн дэлгүүр
5651	Гэр бүлийн хувцасны дэлгүүр
5655	Спорт хувцасны дэлгүүр
5661	Гутлын дэлгүүр
5681	Үслэг эдлэлийн дэлгүүр
5691	Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцасны дэлгүүр
5697	Оёдолчин
5698	Хиймэл үсний дэлгүүр
5699	Бусад эдлэл хэрэглэл, гоёл чимэглэлийн дэлгүүр
5712	Гэрийн тавилга, цахилгаан бараанаас бусад ахуйн барааны дэлгүүр
5713	Хивс, хивсэнцэр, шалны дэвсгэрийн дэлгүүр
5714	Бөс бараа, хөшиг, бүрээсний дэлгүүр
5718	Зуух, зуухны хамгаалалт, жижиг хэрэгслийн дэлгүүр
5719	Бусад гэр ахуйн төрөлжсөн барааны дэлгүүр
5722	Гэр ахуйн цахилгаан барааны дэлгүүр
5732	Цахилгаан хэрэгслийн дэлгүүр
5733	Хөгжмийн дэлгүүр - хөгжмийн зэмсэг, төгөлдөр хуур, нот
5734	Компьютерийн програм хангамжийн дэлгүүр
5735	Дуу бичлэг, хуурцаг, CD, DVD-ний дэлгүүр
5811	Хоол хүнс нийлүүлэгч
5812	Хоолны газар, ресторан
5813	Шөнийн цэнгээний газар, паб
5814	Түргэн хоолны газар
5912	Эм, гоо сайхан, ариун цэврийн барааны дэлгүүр
5921	Шар айраг, вино, архины төрөлжсөн дэлгүүр
5931	Хуучин барааны дэлгүүр

5932	Эртний эдлэлийн дэлгүүр
5933	Ломбард
5937	Эртний эдлэл засварлах үйлчилгээ
5940	Унадаг дугуйн дэлгүүр
5941	Спорт барааны дэлгүүр
5942	Номын дэлгүүр
5943	Бичиг хэрэг, оффисын хангамж, бичгийн болон хэвлэлийн цаасны дэлгүүр
5944	Үнэт чулуу, метал, цаг, үнэт эдлэлийн дэлгүүр
5945	Тоглоомын дэлгүүр
5946	Гэрэл зургийн аппарат, холбогдох хэрэгслийн дэлгүүр
5947	Бэлэг, мэндчилгээ, бэлэг дурсгалын дэлгүүр
5948	Аяллын цүнх, арьсан бүтээгдэхүүний дэлгүүр
5949	Бөс бараа, оёдлын барааны дэлгүүр
5950	Шилэн эдлэлийн дэлгүүр
5970	Уран зураг, гар урлалын хэрэгслийн дэлгүүр
5971	Галарей, уран зургийн худалдаа
5972	Тамга, зоосны дэлгүүр
5973	Шашны эдлэл хэрэглэлийн дэлгүүр
5975	Сонсголын аппарат, дагалдах хэрэгслийн худалдаа
5976	Согог заслын бүтээгдэхүүн худалдаа
5977	Гоо сайхны барааны дэлгүүр
5983	Шатахууны жижиглэн худалдаа /non-automotive/
5992	Цэцгийн дэлгүүр
5993	Тамхины төрөлжсөн дэлгүүр болон цэг
5994	Сонин сэтгүүлийн худалдаа
5995	Тэжээвэр амьтан, амьтны хоол, жижиг хэрэгслийн дэлгүүр,
5998	Майхан, сүүдрэвчний дэлгүүр
5999	Бусад төрөлжсөн барааны дэлгүүр
6010	ПОБ-ын гүйлгээ

6011	АТМ-ын гүйлгээ
6012	Санхүүгийн байгууллага
6051	Банк бус санхүүгийн байгууллага
6211	Үнэт цаасны брокер/дилер
6300	Даатгалын нөхөн төлбөр, даатгалын хураамж
6399	Даатгалын үйлчилгээ
6513	Үл хөдлөх хөрөнгийн агентлаг
7011	Зочид буудал, дэн буудал, амралтын газар
7012	Амралтын байр
7032	Спорт, амралт зугаалгын газар
7210	Угаалга, цэвэрлэгээний үйлчилгээ
7211	Угаалгын газар
7216	Хуурай цэвэрлэгээ
7217	Хивс, бүрээсний цэвэрлэгээ
7221	Гэрэл зургийн студи
7230	Үсчин, гоо сайхны салон
7251	Гутал засвар/малгай цэвэрлэгээ
7261	Оршуулга, чандарлах үйлчилгээ
7276	Татварын зөвлөгөө өгөх үйлчилгээ
7277	Зөвлөгөө өгөх үйлчилгээ
7296	Хувцас түрээс
7297	Массажны газар
7298	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ
7299	Бусад үйлчилгээ
7311	Зар сурталчилгааны үйлчилгээ
7321	Зээлийн мэдээллийн агентлаг
7342	Устгалын үйлчилгээ
7349	Цэвэрлэгээ, арчилгаа
7361	Ажил олгох агентлаг

7372	Компьютерын програмчлалын үйлчилгээ
7375	Мэдээллийн лавлах үйлчилгээ
7379	Компьютер засварын үйлчилгээ
7392	Зөвлөх, олон нийттэй харилцах үйлчилгээ
7393	Мөрдөх агентлаг
7394	Тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ
7395	Зураг засварын үйлчилгээ
7399	Бусад бизнесийн үйлчилгээ
7512	Машин түрээсийн газар
7513	Том оврын машин, чиргүүл түрээслэх үйлчилгээ
7523	Машины зогсоол, гарааш
7531	Автомашин засвар
7534	Дугуй засварын үйлчилгээ
7535	Автомашин будаж засах үйлчилгээ
7538	Автомашины үйлчилгээ үзүүлэх газар
7542	Машин угаалга
7549	Ачих, чирэх үйлчилгээ
7622	Цахилгаан барааны засвар
7623	Агааржуулалт, хөргөлтийн систем засвар
7629	Гэр ахуйн жижиг хэрэгсэл засвар
7631	Цаг, үнэт эдлэл засвар
7641	Тавилга засвар
7692	Гагнуур
7699	Бусад засварын газар
7829	Зураг авалт, видео бичлэгийн газар
7832	Театрын үйл ажиллагаа
7841	Видео хуурцаг түрээсийн газар
7911	Бүжгийн танхим, студи, сургууль
7922	Үзвэр үйлчилгээний билетийн касс

7929	Хамтлаг дуучид
7932	Биллиард, усан сан
7933	Боулингийн газар
7941	Спорт клуб, талбай
7991	Музей ба түүхийн дурсгалт газар, байшин барилга үзүүлэх үйл ажиллагаа, үзэсгэлэн
7992	Гольфын сургалт
7993	Видео тоглоомын хэрэгсэл худалдаа
7994	Видео тоглоомын газар
7995	Мөрийтэй тоглоомын газар
7996	Цэнгэлдэх хүрээлэн, парк болон цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаа
7998	Аквариум
7999	Бусад амралт зугаалгын газар
8011	Эмч
8021	Шүдний эмч
8041	Бариа засал
8043	Нүдний эмч, нүдний шилний газар
8049	Хөлийн эрүүл мэнд, эмчилгээ
8050	Асаргаа, сувилгааны газар
8062	Эмнэлэг
8071	Эрүүл мэнд, шүдний лаборатори
8099	Эрүүл мэндийн үйлчилгээ
8111	Хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ
8211	Бага, дунд, ахлах сургууль
8220	Их дээд сургууль
8241	Эчнээ сургууль
8244	Бизнесийн сургууль
8249	Мэргэжил олгох сургууль
8299	Боловсролын үйлчилгээ
8351	Хүүхдийн цэцэрлэг

8398	Буяны байгууллага болон хандив цуглуулах үйл ажиллагаа
8641	Иргэдийн, нийгмийн, ах дүүсийн нийгэмлэг
8651	Улс төрийн байгууллага
8661	Шашны байгууллага
8675	Автомашин сонирхогчдын холбоо
8699	Гишүүнчлэлийн байгууллага
8734	Шинжилгээ судалгааны лаборатори
8911	Архитектур зураг төслийн үйлчилгээ
8931	Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ
8999	Мэргэжлийн үйлчилгээ
9222	Төрийн үйлчилгээний байгууллагуудын торгууль
9311	Татвар төлөлт
9399	Төрийн бусад үйлчилгээ

ҮНДЭСНИЙ “₮” ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЗАГВАР

I.1 Үндэсний төлбөрийн карт (цаашид “₮ карт” гэх) нь тэгш өнцөгт хэлбэртэй ба дараахь хэмжээтэй байна:

1. Өргөн: $W=85.60 \text{ мм} \pm 0.30 \text{ мм}$;
2. Өндөр: $H=53.98 \text{ мм} \pm 0.30 \text{ мм}$;
3. Зузаан: $T=0.76 \text{ мм} \pm 0.08 \text{ мм}$;
4. Булангийн тойрог: $3.18 \pm 0.30 \text{ мм}$.

I.2 ₮ картын нүүрэн талд дараахь мэдээллүүдийг агуулсан байна:

1. Карт гаргагчийн нэр, лого эсхүл ко-брэнд байгууллагын нэр;
2. Картын дугаар (Хавсралт 12);
3. ₮ картын лого (Хавсралт 13);
4. ₮ картын холограм (Хавсралт 14);
5. Чип (хэрэв үндэсний төлбөрийн картын чиптэй бол ISO/IEC 7816-1/2/3 стандартын шаардлагын дагуу контакт чип, зайнаас унших чип эсхүл хослуулсан байж болно. Чипийг зөвхөн картын нүүрэн талын зүүн хэсэгт картын дугаар дээр байрлана. Хүснэгт 1);
6. Картын хүчинтэй хугацаа (эхлэх болон дуусгавар болох хугацаа, хүчинтэй хугацаа нь хэвлэгдээгүй картын хувьд дуусах хугацаагүй гэж ойлгоно).

I.3 Монголбанкнаас баталсан ₮ картын загварын шаардлагыг хангаж дараахь мэдээллийг гурван шугаманд бичнэ. ₮ картын гадаргуун дээрх тэмдэгтийг товойлгон бичих болон лазераар хэвлэх зэрэг хэвлэлийн технологийг ашиглаж болно:

1. Картын дугаар (Хүснэгт 2);
2. Карт эзэмшигчийн овгийн эхний үсэг болон нэрийн үсгүүд том үсгээр, латин галигаар бичигдэнэ. (Хүснэгт 3);
3. Картын хүчинтэй хугацаа нь сар, жил гэсэн дараалалтай, тус тус 00 гэсэн 2 оронтой аравтын тооллын тоо байна. (Хүснэгт 4) Картан дээрх хугацаа нь соронзон тууз эсхүл чипний мэдээлэлтэй ижил байдаг.

Хүснэгт 1. Чипний стандарт байрлал, хэмжээ

№	Тайлбар	Байрлал, хэмжээ
1	Контакт чип	Картын зүүн хэсэгт картын дугаарын дээр, ISO7816 стандартын дагуу байрлана.
2	Өндөр	9.32 мм
3	Өргөн	9.62 мм
4	A. Чипний дээд булангаас картын дээд ирмэг хүртэл	19.23 мм
5	B. Чипний зүүн булангаас картын зүүн ирмэг хүртэл	10.25 мм
6	C. Чипний доод булангаас картын дээд ирмэг хүртэл	28.55 мм
7	D. Чипний баруун булангаас картын зүүн ирмэг хүртэл	19.87 мм

Хүснэгт 2. Ү картын дугаар бичих стандарт

№	Тайлбар	Үзүүлэлт
1	Картын дугаарын тэмдэгтийн хэвтээ төвийн шугамаас картын доод ирмэг хүртэл	21.42 мм ±0.12 мм
2	Картын дугаарын эхний тэмдэгтийн хэвтээ төвийн шугамаас картын зүүн ирмэг хүртэл	10.18 мм ±0.25 мм
3	Картын дугаарын сүүлийн тэмдэгтийн хэвтээ төвийн шугамнаас картын зүүн ирмэг хүртэл	75.50 мм ±0.76 мм
4	Картын дугаарын товойлгосон тэмдэгтүүдийн доод ирмэгээс БИН дугаарын эхний 4 тэмдэгт хүртэл	1.19 мм ±0.10 мм
5	Товойлгон бичсэн картын дугаарын фонт	Farrington 7B, үүнээс жижиг, 12Pt-с багагүй
6	Товойлгон бичсэн картын дугаарын тэмдэгтийн өндөр	5 мм ±0.10 мм
7	Картын дугаарын зэргэлдээ хоёр тэмдэгтийн босоо төвийн шугам хоорондын зай	3.63 мм ±0.10 мм
8	Товойлгон бичсэн тэмдэгтүүдийн гүдгэрийн өндөр	0.46 мм
9	Эхний тэмдэгтийн босоо төвийн шугам, картын дугаарын сүүлийн тэмдэгтийн хоорондын хамгийн их хуримтлагдсан хэмжээ	±0.08 мм

Хүснэгт 3. Карт эзэмшигчийн овог, нэр бичих стандарт

№	Тайлбар	Хэвлэлтийн шаардлага
1	Карт эзэмшигчийн нэрийн байрлал	Карт эзэмшигчийг тодотгох хэсэгт 2 дахь мэдээллийн шугаманд товойлгон бичнэ.
2	Карт эзэмшигчийн нэрийг товойлгон бичих тэмдэгтийн фонт	Letter/number font in OCR-B size I
3	Карт эзэмшигчийн нэрийн хэсэг дэх мэдээллийн шугам бүрийн өндрийн хэмжээ	4 мм ± 0.10 мм
4	Карт эзэмшигчийн нэр бичсэн тэмдэгтийн хоорондын ердийн зай	2.54 мм ± 0.10 мм
5	Эхний тэмдэгтийн босоо төвийн шугамнаас картын зүүн ирмэг хүртэл	≥7.65 мм ± 0.30 мм
6	Нэр тодотгох хэсгийн доод булангаас картын доод ирмэг хүртэл	≥2.54 мм

7	Товойлгон бичсэн тэмдэгтийн гүдгэрийн өндрийн хэмжээ	0.46 мм
8	Мэдээллийн шугам бүрийн эхний тэмдэгт болон сүүлийн тэмдэгтийн босоо төвийн шугамын хооронд хуримтлагдсан хамгийн дээд хэмжээ	±0.08 мм

Хүснэгт 4. Картын хүчинтэй хугацаа бичих стандарт

№	Хэсэг	Үзүүлэлтүүд болон хэвлэлтийн шаардлагууд
1	Дуусах хугацааг товойлгон бичих байрлал	Карт эзэмшигчийн мэдээллийг эхний мөрт товойлгон бичнэ
2	Дуусах хугацааны тайлбар	1. Дуусах хугацааны гэсэн тэмдэглэгээний зүүн талд нь хэвлэх 2. Картын үндсэн өнгөнөөс ялгарахаар хэвлэх 3. Helvetica type фонтоор 4-6 хэмжээтэй
3	Бусад мэдээллийг товойлгон бичих байрлал	Карт эзэмшигчийн мэдээллийн хэсгийн 2, 3 дугаар мөрт товойлгон бичих
4	Дуусах хугацааны фонт, тэмдэгтүүдийн өндөр	OCR-B фонтоор 1 хэмжээтэй тэмдэгтүүд
5	Дуусах хугацаанд зориулсан мэдээллийн шугамны өндрийн дээд хэмжээ	4 мм ±0.10 мм
6	Дуусах хугацааны тэмдэгтүүдийн хоорондын ердийн зай	2.54 мм ±0.10 мм
7	Дуусах хугацааны эхний тэмдэгтийн босоо төвийн шугамнаас картын зүүн ирмэг хүртэл	≥7.64 мм ±0.10 мм
8	Товойлгон хэвлэсэн тэмдэгтүүдийн гүдгэрийн өндөр	1.46 м

1.4 ₮ картын ар тал дараахь мэдээллийг агуулсан байна:

1. Соронзон тууз нь ISO 7811 стандартын дагуу мэдээллийг хадгална. Соронзон туузын өгөгдлийн хэмжээ болон техникийн үзүүлэлт (GB/T 19584-2004), ISO/IEC 7811 (2, 4-6)-д заасан шаардлагатай нийцсэн байна;
2. Гарын үсгийн хэсэг. Гарын үсэг зурах наалт нь үндэсний төлбөрийн картын нэртэй адил “₮ карт” гэсэн үг бүхий байна;
3. ҮЦГТ-ийн лого нь картын зүүн доод хэсэгт байрлана (Хавсралт 15);
4. Карт гаргагчийн картыг ашиглах боломжтой төлбөрийн картын бусад сүлжээний логог ҮЦГТ-ийн логоны баруун талын хэсэгт нэмж байрлуулж болно;
5. Карт гаргагчийн мэдээллийг ҮЦГТ-ийн лого болон нэмэлт сүлжээний логоны баруун талын хэсэгт бичнэ. (Карт гаргагчийн нэр, эзэмших эсхүл ашиглахыг хориглосон заалт, хаяг, картын талаар мэдээлэл авах утас, факсын дугаар, цахим хуудасны хаяг зэрэг мэдээлэл байж болно).

- 1.5 Гарын үсгийн хэсэг нь карт эзэмшигч гарын үсэг зурахад зориулагдсан дараахь стандартыг хангасан талбай байна:
1. Өргөн A: 40мм-ээс багагүй байна (± 0.3 мм);
 2. Өндөр B: 10.00мм (± 0.3 мм);
 3. Талбарын баруун ирмэгээс картын баруун ирмэг хүртэл C: 25.00мм (± 0.3 мм);
 4. Талбарын дээд ирмэгээс картын дээд ирмэг хүртэл D: 19.50мм (± 0.3 мм).
- 1.6 Карт гаргагч нь өөрийн картын бүтээгдэхүүний нэр төрөлд тохирсон загвараар ₮ карт хэвлэж болно. Бүтээгдэхүүний нэр, картын төрөл болон худалдааны тэмдэгтийг хэвлэхдээ товойлгох аргыг ашиглахгүй. Ямар ч фонтоор хэвлэсэн тэмдэгтийн ердийн зай нь хоорондоо 2.54 мм, мэдээллийн шугамын өндрийн хэмжээ 5 мм-с хэтрэхгүй байна.

₮ КАРТ ЭЗЭМШИГЧИЙН КАРТЫН ДУГААР


- 1.1. ₮ карт эзэмшигчийн картын дугаар нийт 16 оронтой дараахь бүтэцтэй байна:
 1. Карт гаргагчийн таних дугаар – нийт 6 оронтой;
 2. Картын дансны дугаар – 9 оронтой;
 3. Хяналтын дугаар – 1 оронтой.
- 1.2. ₮ карт гаргагчийн таних дугаар нь дараахь стандарттай байна:
 1. Карт гаргагчийн таних дугаар нь нийт 4 оронтой. Үүнийг Үндэсний стандартын байгууллагаас MNS ISO/IEC 7812-1:2004, MNS ISO/IEC 7812-2:2005 стандартын дагуу салбарын таних дугаар болох 9-өөр эхэлж, ISO3166 стандартын дагуу Монгол Улсын код болох 496 дугаартай байна.
 2. Карт гаргагчийн дугаар 2 оронтой байна. Монголбанк энэ дугаарыг олгоно.
- 1.3. Картын дансны дугаар нийт 9 оронтой байх бөгөөд ₮ карт эзэмшигчийн картын төрлөөс хамаарч карт гаргагч олгоно.
- 1.4. Хяналтын дугаар нь нийт 1 оронтой байна. MNS ISO/IEC 7812-1:2004 стандартад зааснаар Модуло 10 “2 дахин-нэм-2 дахин” Лухнийн томъёогоор тооцно. Үүнд:
 1. Картын дугаарын баруун талын захын цифрээс эхлэн орон алгасан 2-оор үржүүлнэ;
 2. Нэгдүгээрт гарсан тоонуудын оронг бүрдүүлэгч бүрийг болон эхний үед өөрчлөлт ороогүй алгассан оронгуудын хамт нэг бүрчлэн нэмнэ;
 3. Хоёрдугаарт гарсан нийлбэрийг тэр тооны дараагийн 0-ээр төгссөн их тооноос хасна. (Энэ нь нийлбэрийн бага дарааллын тооны аравтын гүйцээгчийн тооцоолсонтой тэнцүү байна. Хэрэв хоёрдугаар тооцооллоос гарсан нийлбэр нь өөрөө 0-ээр төгссөн (30, 40 гэх мэт) тоо бол хяналтын цифр нь 0 болно).

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН ₮ КАРТЫН ЛОГО, ТҮҮНИЙ БАЙРШИЛ


1.1 ₮ картын лого дараах загвартай байна.



1.2 Логоны үндсэн байгуулалт дараах бүтэцтэй байна.



1.3 ₮ картын лого нь картын нүүрэн талд дараах талбарт байршина.



Хүснэгт 2. Логоны байршлын стандарт

№	Тайлбар	Шаардлага
1	Логоны байршил	Картын өнгөөс үл хамаарч логоны байршил картын баруун доод буланд 10 мм диаметртэй байршина
2	Өндөр, өргөн	10.00 мм
3	Картын баруун доод булангаас логоны ирмэг хүртэл	5.00 мм
4	Картын баруун булангаас лого хүртэл	5.00 мм

1.4 ₮ картны лого дараах өнгөний кодтой байна.

	СПОТ	СМУК	RGB	HEX
₮ карт (цэнхэр)	Pantone 286 c	100/75/0/0	0/51/160	0033A0
₮ карт (цагаан)		0/0/0/0	255/255/255	ffffff

СПОТ, СМУК өнгөний систем нь хэвлэлийн өнгө бөгөөд RGB, HEX нь дэлгэцийн өнгө юм. Логог дэлгэцийн өнгөний кодоор хэвлэлд өгч болохгүй. Хэвлэлийн өнгийн кодыг дэлгэц буюу цахим орчинд хэрэглэж болохгүй.

Логоны өнгөний сонголт

Цайвар дэвсгэр



Цагаан өнгийн дэвсгэр бүхий карт дээр ₮ лого үндсэн хөх өнгөөрөө байршина.

Бараан дэвсгэр



Хөх дэвсгэр дээр ₮ лого цагаан өнгөөр байршина.

Зурагтай



Бусад олон өнгөт дэвсгэр дээр ₮ лого цагаан суурьтай хөх өнгөөр байршина.

Platinum



Хар болон platinum дэвсгэр өнгөн дээр
TBS лого цагаан өнгөөр байршина.

Gold



Алтан дэвсгэрт карт дээр
TBS лого цагаан өнгөөр байршина.

Silver



Мөнгөлөг саарал өнгийн дэвсгэр дээр
TBS лого мөнгөлөг саарал өнгөөр байршина.

₮ КАРТЫН ХОЛОГРАМ, ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ХЭСГИЙН ЗАГВАР, ТҮҮНИЙ БАЙРШИЛ


1.1 ₮ картын холограм дараах загвартай байна.



1.2 Гарын үсэг зурах хэсэг дараах загвартай байна.



1.3 Холограм, гарын үсэг зурах хэсгийн байршил, харьцаа



Хүснэгт 1. Картын ар талд холограм болон гарын үсэг зурах хэсэг байрлах стандарт

№	Тайлбар	Шаардлага
1	Картын өргөн	86 мм
2	Картын өндөр	54 мм
3	Картын баруун талаас холограм хүртэл	4.00мм
4	Картын доод ирмэгээс холограмын доод ирмэг хүртэл	4.00 мм
5	Картын доод ирмэгээс гарын үсэг зурах хэсэг	26.00 мм
6	Картын зүүн талаас гарын үсэг зурах хэсгийн зүүн ирмэг хүртэл	4.00 мм
7	Гарын үсэг зурах хэсгийн урт	50.00 мм

ҮНДЭСНИЙ ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЛОГО, ТҮҮНИЙ БАЙРШИЛ

1.1 Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-ийн лого дараах өнгөний кодтой байна.


Хүснэгт 1. Логоны өнгөний код

	C	M	Y	K	R	G	B
Логоны хар хөх өнгө	100	100	10	25	37	33	109
Логоны шар өнгө	0	20	100	0	255	203	5
Логоны цэнхэр өнгө	100	60	0	0	0	102	179


1.2 Лого нь дараах загвартай байна:



ҮЦГТ-ийн логоны өнгөний сонголтыг картын бэлдэцийн дэвсгэр өнгөнөөс хамаарч цоолбор хэлбэрээр байршуулж болно. **Жишээлбэл:**



1.3 ҮЦГТ-ийн логоны байршлын стандарт.



Хүснэгт 2. Логоны байршлын стандарт

№	Тайлбар	Шаардлага
1	Өргөн (тусгал)	13.6 мм ± 0.30 мм
2	Өндөр	10.00 мм ± 0.30 мм
3	Картын зүүн ирмэгээс логоны зүүн ирмэг хүртэл	3.00 мм ±0.10 мм
4	Картын доод ирмэгээс логоны доод ирмэг хүртэл	3.00 мм ±0.10 мм